

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-32</i>
<hr/>	
<i>1. Ундны усны хангамж, нөөц аюулгүй байдлын талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох</i>	<i>3-32</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 58 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан;
Эмнэлгийн чөлөөтэй: П.Анужин, С.Батболд;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан.

Нэг. Ундны усны хангамж, нөөц аюулгүй байдлын талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, мөн газрын мэргэжилтэн Д.Давааням, Барилга, хот байгуулалтын яамны Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Г.Цогтсайхан, мөн хэлтсийн ахлах шинжээч Р.Батчимэг, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга С.Сүнчин, мөн яамны Урьдчилан сэргийлэлт, хяналт зохицуулалтын хэлтсийн дарга Б.Туяа, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Б.Баясгалан, Б.Золбоо, Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Пүрэвдулам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан, Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Ц.Тулга, мөн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяа, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Болдбаатар, мөн газрын Ус ашиглалтын хэлтсийн дарга У.Өлзийцэцэг, Усны нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Түвшинжаргал, Усны хяналт шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Мөнхзул, мөн хэлтсийн мэргэжилтэн Л.Хишигдулам, Нийслэлийн Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхтайван, мөн газрын Хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч Б.Ганболд, Ойн хэлтсийн дарга О.Тэмүүжин, Ус сувгийн удирдах газрын дарга Ц.Төрхүү, мөн газрын Ерөнхий инженер Ж.Дагвасүрэн, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг, мөн албаны Кадастрын хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн Ж.Гал, Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Хими, хор судлалын лабораторийн эрхлэгч Л.Уранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Ундны усны хангамж, нөөц аюулгүй байдлын талаарх Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ,

Барилга, хот байгуулалтын яамны мэдээллийг Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо нар тус тус танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Э.Бат-Амгалан, Б.Баттөмөр, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Ус сувгийн удирдах газрын дарга Ц.Төрхүү, Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Ц.Тулга, Нийслэлийн Байгаль орчны газрын Ойн хэлтсийн дарга О.Тэмүүжин, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга С.Сүнчин, мөн яамны Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Б.Баясгалан, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн Ж.Гал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Ундны усны хангамж, нөөц аюулгүй байдлын талаарх холбогдох байгууллагуудын мэдээллийг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 52 минут үргэлжилж, 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 13 цаг 58 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг танилцуулъя. Б.Энх-Амгалан ирсэн, Н.Алтанхуяг чөлөөтэй, Г.Амартүвшин чөлөөтэй, П.Анужин гишүүн өвчтэй, Э.Бат-Амгалан гишүүн ирсэн, Б.Баттөмөр гишүүн ирсэн, Х.Баделхан гишүүн чөлөөтэй, С.Батболд гишүүн өвчтэй, Б.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Х.Булгантуяа гишүүн ирсэн, Д.Ганбат гишүүн орон нутагт томилолттой, Б.Дэлгэрсайхан гишүүн орон нутагт томилолттой, Н.Наранбаатар гишүүн ирсэн, Ц.Сэргэлэн гишүүн ирсэн, Д.Цогтбаатар гишүүн ирсэн, Н.Энхболд гишүүн ирсэн.

Ингээд хуралдааны ирц бүрдсэн тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хүн ам, үйлдвэр, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн баталгаатай хүрэлцээтэй усаар найдвартай хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон эко системийн тэнцвэрт байдлыг тогтвортой хадгалахад чиглэсэн бодлого хэрэгжүүлж, усны нөөцийг хамгаалах, хэмнэлттэй, зүй зохистой ашиглахад талуудын оролцоог

хангах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар Ундны усны хангамж, нөөц, аюулгүй байдлын талаарх мэдээллийг сонсоно.

Ундны усны хангамж, нөөц аюулгүй байдлын талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох

Хэлэлцэх асуудлыг гишүүдэд тараасан байгаа. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор ажлын хэсгийг оруулъя. Хариулах хүмүүс нь микрофон дээр суугаарай.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын 3.4.2.4-д хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна гэж, 3.4.4-д томоохон хот, суурин газарт агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно гэж, 3.5.1.1-д усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгож, ашиглагч нь хамгаалах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгож хүн амын ундны усны хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж, 3.5.11.2-т усны үнэлэмжийг нэмэгдүүлэх, нөөцийг хамгаалах, өсгөх ажлыг санхүүжүүлэх механизмыг тодорхой болгох, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн усны эрэл, хайгуулын зардлыг эргэн төлүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалт хийнэ гэж тус тус заасны дагуу өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар ундны усны хангамж, нөөц, аюулгүй байдлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтны мэдээллийг сонсож байгаа юм.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Ц.Уранчимэг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Д.Давааням тус яамны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн, Барилга, хот байгуулалтын яам Энхтүвшиний Золбоо Барилга, хот байгуулалтын дэд сайд, Г.Цогтсайхан Барилга, хот байгуулалтын яамны Барилга инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн аж ахуй инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга, Р.Батчимэг тус яамны Барилга инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн аж ахуй инженерийн дэд бүтцийн хэлтсийн ахлах шинжээч, Эрүүл мэндийн яам. С.Сүнчин Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Сүнчин дарга байна уу. Б.Туяа тус яамны Урьдчилсан сэргийлэлт хяналт зохицуулалтын хэлтсийн дарга, Б.Баясгалан тус яамны Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч, Л.Пүрэвдулам тус яамны Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Б.Золбоо тус яамны Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч, С.Өнөрсайхан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, Хот байгуулалт, хөгжлийн газар. Ц.Тулга Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга, Б.Оюунтуяа тус газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга, Усны газар. Я.Болдбаатар Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, У.Өлзийцэцэг тус газрын Ус ашиглалтын хэлтсийн дарга, Д.Түвшинжаргал тус газрын Усны нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Д.Мөнхзул тус газрын Усны хяналтын шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн, Л.Хишигдулам тус газрын

Усны хяналтын шинжилгээний мэргэжилтэн, Нийслэлийн байгаль орчны газраас Р.Энхтайван Нийслэлийн байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Ганболд тус газрын Хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч, О.Тэмүүжин тус газрын Ойн хэлтсийн дарга, Ус сувгийн удирдах газар. Ц.Төрхүү Ус сувгийн удирдах газрын дарга, Ж.Дагвасүрэн тус газрын Ерөнхий инженер, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба. Г.Батзориг Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга, Б.Эрдэнэтуул тус албаны Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ж.Гал тус албаны Кадастрын хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн, Стандарт хэмжилзүйн газрын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори. Л.Уранчимэг тус лабораторийн Хими, хор судлалын лабораторийн эрхлэгч, Д.Сайнжаргал Нян судлалын лабораторийн эрхлэгч.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээллийг Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгье. 2 номерын микрофон. Та индэр дээр танилцуулах уу. Тэгвэл индрийн микрофоныг өгөх үү. Бат-Эрдэнэ сайдыг индэрт урья. Индэрийн микрофоныг өгье. Манай ажлын албаныхан тэр нөгөө презентаци удирддаг юмаа өгөөч. Удирдлагыг нь өгөөрэй.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм байнгын хорооны дарга болон Улсын Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Энэ удаагийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ундны устай холбоо бүхий асуудлаар усны нөөц, ашиглалт, хамгаалалт, усны чанар, аюулгүй байдал, тулгамдаж буй асуудлуудаар Та бүхэнд мэдээлэл өгье.

Монгол орны усны нөөц, нуур тойрон маань 500км³, гол мөрөн 34.6км³, мөстөл 19.4 км³, газрын доорх ус маань 10.8км³ гэж явдаг. Зөвхөн 2.5 хувь нь л цэнгэг ус эзэлдэг байгаа. 97.5% нь бол далай тэнгисийн шорвог ус эзэлдэг. Монгол орны ус ашиглалтын хувьд бол 2020-2022 оны Монгол орны ус ашиглалтыг та бүхэндээ харуулъя. Мал аж ахуй 31 хувь, Уул уурхай 15 хувь, Эрчим хүч, дулаан 8 хувь, Усалгаатай газар тариалан 25 хувь, унд, ахуйн 14 хувь, үйлдвэр ахуйн үйлчилгээнд 7 хувь усыг бол ашиглаж байна.

Гол мөрний урсац бүрэлдэх эхтэй холбоо бүхий ялангуяа Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт гол мөрний урсац бүрэлдэх эх гэж гадаргын ус урсцын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс сав газрын эх гэж тодорхойлсон байдаг. Монгол орны гол мөрний усны нөөцийн 70 хувь нь Алтай, Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсгээс бүрддэг. Монгол Улсын Их хурлын 2009 онд Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг гаргаж байлаа. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 120-дугаар тогтоолоор гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөө зорилт бүхий талбайд холбогдох арга хэмжээг авах, нөхөн сэргээлт хийх журмыг Засгийн газрын 235 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 289, 302 дугаар тогтоол мөн одоо Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэхүүн эхийн хилийн заагийн солбилцолд тус тус өөрчлөлтийг өнгөрсөн хугацаанд оруулсан байдаг. Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт тусгасан гол мөрний урсац бүрэлдэх эхийн

хамгаалалтын зорилго 2025 он гэхэд бид нар 55 хувьд аваачих, 2030 онд 60, 2050 онд 75 хувьд аваачих ёстой байгаа. 2022 оны байдлаар бол 49.91 хувьтай хамгаалалтад авсан гэдэг ийм тооцоо, тоон судалгаа мэдээллүүд байна.

Гол мөрний урсац бүрэлдэх эхийг өнгөрсөн 2021 оны эцсээр 49.91 буюу ер нь бол 2007 оноос хойш бол байнгын өсөлттэй. Саяын алсын хараа 2050-д дурдсаны дагуу бид нар бол байнгын өсөлтийг бол үргэлжлүүлэн хамгаалалтад авч явах ёстой байгаа.

Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс гэж Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д усны сан бүхий газар гэж нуур цөөрөм, цөөрөм тойром, гол, мөрөн, горхи, булаг шанд, усан сан, рашаан намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүс газрыг хэлнэ гэж томъёолсон байдаг.

Сав газрын захиргаа Усны тухай хуулийн 17.1.3-аар бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжлийн зөвлөмжөөр хангах үүрэгтэй. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бол Усны тухай хуулийн 11.1.4-өөр Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн хамгаалалтын бүсийг тогтоох ёстой. Үүний дараагаар бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бол Усны тухай хуулийн 12.1.4, 13.1.6- д заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллах ийм хуулийн заалттай. Байгал орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 230/127 дугаар хамтарсан тушаалаар усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг бол баталж өгсөн байдаг. 2022 оны байдлаар нийт 1368 ус хангамжийн эх үүсвэрийн худагт эрүүл ахуйн бүсийг тогтоож, хот суурин газруудын хүн амын төвлөрсөн эх үүсвэрүүдэд эрүүл

ахуйн бүс болон тэжээгдлийн мужийг болбол тогтоож өгсөн байдаг.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам байнга ажиллаж байна. Өнгөрсөн 2022 онд бол АТГ-тай 2 ч удаагийн томоохон хэлэлцүүлгийг өрнүүлсэн. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар төвлөрөх ёстой орлогоос эргэн зарцуулах буюу одоо хуулийн хэрэгжилтийг хангуулах дээр аймаг, нийслэлийн удирдлагууд бол маш хангалтгүй ажиллаж байгаа. Үүнтэй холбоотой бас өнгөрсөн 7 хоногт бид нар Эрүүгийн хуулийн 24 дүгээр заалтыг үндэслэн Улсын ерөнхий прокурорт Ойн сан болон усан сан хамгаалалтын бүсийн зөрчилтэй холбоо бүхий асуудал дээр бол хамтран ажиллах саналыг бол явуулсан байгаа.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль хэрэгжилт дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам мөн ажиллаж байгаа. Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлсөн, чөлөөлсөн дүн, хаягдал усны хэмжээ, ус бохирдуу усны төлбөр, технологийн хаягдал ус гэх мэтчилнээр тодорхой тооцоо, судалгаануудыг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хийж та бүхэнд хүргүүлсэн байгаа. Энэ дээр дэлгэрэнгүй асуулт дээр бид нар хариулаад явна.

Монгол орны ундны усны чанарын үзүүлэлтийг бүсчлэлийн хэлбэрээр судалгаа шинжилгээний ажлууд бол хийгдсэн. Энэ дээр бол ундны чанар дээж авах 11 дүгээр бүлэг буюу гүний уснаас дээж авах MNS/ISO5667112000 гэдэг ийм стандарт д байдаг. Хангайн бүс дээр бол хийсэн судалгаа усны чанарын үзүүлэлтээр бол шаардлага хангасан нь 35 хувьтай, шаардлага хангаагүй нь 65 хувьтай гарч байгаа юм. Баруун бүс дээр шаардлага хангасан нь 32 хувьтай, шаардлага хангаагүй нь 68 хувьтай гарч байгаа юм. Төвийн бүс дээр шаардлага хангасан нь 52 хувьтай, шаардлага хангаагүй нь 48 хувьтай, зүүн бүс дээр

шаардлага хангасан 25 хувь, шаардлага хангаагүй хангаагүй 75 хувь, говийн бүс дээр шаардлага хангасан 14 хувь, шаардлага хангаагүй 86 хувьтай гарч байгаа. Ингэхээр гүний уснаас авсан дээж, усны чанарын үзүүлэлт бол шаардлага хангаагүй гэдэг нь Монгол Улс даяар бол дийлэнх хувь гарч байгааг та бүхэн харж байна.

Монгол орны ундны усны чанарын үнэлгээг мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас холбогдох байгууллагуудтай хамтарч хийж байгаа. Гадаргын усны чанарын үнэлгээ 2020 оны байдлаар бол цэвэр 42.4 хувьтай, бага бохирдолтой нь 5.8 хувьтай, маш бохир нь 1.9 хувьтай, маш цэвэр нь бол 50.6 хувьтай. Гадаргын усны чанарын үнэлгээ бага бохирдолтой нь 4.6 хувьтай, бохирдолтой 1.3 хувьтай, маш бохир 0.6 хувьтай, маш цэвэр 29.3 хувьтай, цэвэр 64 хувьтай байгаа.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжтай холбоо бүхий асуудлууд байна. Төв цэг цэвэрлэх байгууламж дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2022 онд Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарсан хяналт шалгалтын үйл ажиллагааг болбол явуулж байсан. Төв цэвэрлэх байгууламж маань бол хоногт 170000м3 хаягдал ус, бохир ус хүлээн авч, цэвэршүүлэх хүчин чадалтайгаар 1964 онд байгуулагдсан, MNS49432015 стандартын шаардлага хангаагүй маш их бохирдолтой 150-160000м3 буюу 10 тонны багтаамжтай 15-16000 машин бохир усыг өдөр бүр Туул голд нийлүүлж байгаа юм. Энэ дээр бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тодорхой төлбөрийг тогтоосон. Нөхөн төлбөртэй холбоо бүхий асуудлуудыг бол гаргаж тавьсан. Нийслэлийн Засаг даргаас бол Ус сувгийн удирдах газар бол энэ мөнгийг төлөх боломжгүй гэдэг ийм албан тоотыг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамд ирүүлсэн байдаг. Энэ дээр бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам миний саяын хэлсэн Улсын ерөнхий прокурорт

Ойн сан болон усан сан ашиглалттай холбоо бүхий асуудал дээр хамтран ажиллах энэ саналыг бол мөн хүргүүлсэн. Үүний дагуу бол бас тодорхой хэмжээний албан даалгаврууд гараад цаашидаа явах байх гэж итгэж байгаа.

Туул голын усны чанарын индексийн үнэлгээ 2017-2021 оны үнэлгээг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас мөн хийсэн байгаа. Туул голын 3.5 хувь нь бол маш их бохирдолтой гэдэг ийм дүн шинжилгээнүүд бол гарсан. Цаашидаа Туул голын усны чанарын бохирдолтой холбоо бүхий асуудал бол хамгийн их бохирдлыг Төв цэвэрлэх байгууламж болон цэвэрлэх байгууламжуудаас нийлүүлж байгаа гэдэг нь нэгэнт тогтоосон. Мөн одоо хөрсний бохирдолтой холбоо бүхий асуудал бол энд давхар хөндөгдөж байгаа.

Монгол орны ундны усны чанарын үнэлгээг мөн хийсэн. Нийслэл хотын суурьшлын нөлөөгөөр Туул голын бохирдолд нөлөөлдөг хамгийн том эх үүсвэр нь бол Төв цэвэрлэх байгууламж болон нийслэлд үйл ажиллагаа явуулдаг бусад цэвэрлэх байгууламжаас дутуу цэвэрлэгдсэн ус Туул гол түүний цутгал голуудад нийлүүлэгдэж байгаа. Үүнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн урьдчилсан цэвэрлэх байгууламжаас гарч буй хаягдал ус Улиастай гол, Дамбадаржаагийн цэвэрлэх байгууламж, Сэлбэ голд, Баянгол буюу Найрамдал зуслангийн цэвэрлэх байгууламж Баянголд, Төв цэвэрлэх байгууламж болон Нисэх, Био тосгон, Био Комбинатын цэвэрлэх байгууламжууд нь цэвэрлэсэн хаягдал бохир усаа Туул голд тус тус нийлүүлдэг байгаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2022 он, 2023 онд бас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй холбоо бүхий асуудлыг хөндсөнөөр бол тухайн хаягдлыг бас шууд Улиастайн гол руу цутгадаг байсан хэлбэрийг таслан зогсоосон байгаа.

Тулгамдаж байгаа асуудлууд байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас ирүүлсэн мэдээллээр 2022 оны байдлаар Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд газар эзэмших 4827, өмчлөх 1071, энгийн хамгаалалтын бүсэд эзэмших 20450, өмчлөх 7358 нэгж талбар, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужид газар эзэмших 124778, өмчлөх 77314 нэгж талбар бол тус тус олгогдсон байгаа. Тус олгогдсон газруудтай холбоотойгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас бас холбогдох арга хэмжээг авч байгаа боловч хууль, эрх зүйн орчин дээр тодорхой нийслэлээс болон дүүргээс бусад аймгаас олгосон газар олголтын зөвшөөрөлтэй холбоо бүхий асуудлууд хөндөгдөж байгаа.

Усны тухай хууль, Ойн тухай хууль бол Монгол Улсад хүчин төгөлдөр дагаж мөрдөх хуулиудын нэг. Нийслэлийн болон аймгийн ойн хууль, Усны хууль гэдэг ойлголт байхгүй. Тийм учраас Усны тухай хууль болон Ойн тухай хуулийг зайлшгүй мөрдөж ажиллахыг бол байнгын шаардаж байгаа.

Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоохтой холбоо бүхий 2016 оны 4 сарын 5-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гарсан байдаг. Энэ бол өнөөдөр бас Дунд гол дээр баригдсан усан паркаас гадна сүүлийн үед хөндөгдөж байгаа Ривер Гарден, Хан Хиллс гэсэн энэ хотхонуудын хажуу талын бургасыг ихээр сүйтгэсэн газартай, барилгажих явц явагдаж байгаа газартай холбоо бүхий асуудал байгаа. Ингээд 2015 онд жишээлбэл 4 сарын 5-ны өдөр 50 дугаар тогтоолыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Баттулга дарга батлан гаргаснаар онцгой хамгаалалтын бүсийг байхгүй болгож энэ дээр бол барилгажих процессыг бол мөн явуулсан байдаг. Цаашидаа бид нар Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс, усны сан

бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс гэх мэтчилнээр энэ бүсүүдийг тогтоохтой холбоо бүхий асуудлыг бас хууль, эрх зүйн орчинд сайжруулах шаардлагатай гэж үзэж байгаа.

Усны чанарын дараах стандартуудыг шинэчлэн боловсруулаад байгаа. Үүнд бол усны чанар дээж авах хөтөлбөр боловсруулах MNS/ISO 566712002, ундны чанар дээж авах, гүний уснаас дээж авах MNS/ISO 5566720112000, усан орчмын чанарын үзүүлэлт, ерөнхий шаардлага, MNS 45861998 гэсэн тодорхой стандартуудыг бол бид нар цаашидаа үргэлжлүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байгаа. Илтгэж дууслаа. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Бат-Эрдэнэ сайдад баярлалаа. Нэгмөсөн мэдээллээ сонсчхоод дараа нь асуулт асууя. Одоо Барилга, хот байгуулалтын яамны мэдээллийг Барилга, хот байгуулалтын дэд сайд Энхтүвшиний Золбоо танилцуулна. Золбоо сайдыг индэрт урья. Золбоо сайд наанаасаа тайлбарлах юм уу. Индэр гарах юм уу презентац уу. 1 номер дээр суучих. Ундны усны хангамж, нөөц, аюулгүй байдлын асуудлаар Барилга, хот байгуулалтын дэд сайд Энхтүвшиний Золбоо танилцуулга хийнэ. 1 номерын микрофоныг өгье. 1 номерын микрофон дээрээс танилцуулга хийчих. 2 номер асчихсан байна, солиод суучих.

Нийслэлийнхэн та нар дарга нараа дуудаадхаач. Шийдвэр гаргадаг дарга нараасаа дуудаадах. Тэр нийслэлийн орлогч дарга байна уу. Хурлын дарга чинь байна уу. Засаг дарга чинь байна уу. Тэр газрын албаны дарга чинь хаана байгаа юм. Хэдэн үүрэг гүйцэтгэгч явуулчхаад. Энэ чинь танай асуудал яригдаж байна шүү дээ. Тийм учраас тэр дарга нараа дууд. Золбоо сайдад мэдээллээ эхэлье.

Э.Золбоо: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэж байна. Бат-Эрдэнэ сайдын тавьсан мэдээлэлтэй зарим зүйлүүд давхцаж байгаа учраас цаг хэмнэх үүднээс товч бөгөөд тодорхой хариуцаж байгаа ажлынхаа талаар мэдээлэл өгье гэж бодож байна.

Барилга, хот байгуулалтын яам бол цэвэр ус хангамж ариутгах татуургын асуудлыг хариуцаж ажилладаг. Өнөөдөр Монгол улсын хэмжээнд ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд нийтдээ 180,000 орчим метр куб бохир ус цэвэрлэх байгууламж руу ирж байгаа. Гэтэл манай цэвэрлэх байгууламж бол хоногийн 150,000 орчим метр куб бохир ус хүлээн авах хүчин чадалтай 1964 онд байгуулагдсан. Тухайн үедээ бол 220,000 метр кубийг цэвэрлэх боломжтой байсан бол одоо энэ олон жилийн дараа энэ хуучирсны улмаас бол 150 мянгыг хүлээж авах хүчин чадалтай. Тэгээд энэ цэвэрлэх байгууламж маань бол 2 учир шалтгааны улмаас бохир усыг яг одоо бүрэн 100 хувь цэвэрлээд Туул гол руу нийлүүлж байгаа нөхцөл байдлыг бол бүрдүүлж чадахгүй байгаа. Нэгдүгээрт бол сая хоногийн 150 мянгийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламж маань бол 180-200 мянгыг хүлээж авч байгаа.

Хоёрдугаарт цэвэрлэх байгууламж руу ирж байгаа бохир уснууд бол тэр чигээрээ ахуйн хэрэглээний бохир ус байх ёстой. Гэвч өнөөдөр бол ахуйн хэрэглээнээс гадна энэ үйлдвэрүүдийн бүх бохир уснууд тухайн үйлдвэрүүд дээрээ урьдчилсан цэвэрлэх байгууламжаар орохгүйгээр ирж бохирдуулж байгаа учраас цэвэрлэх байгууламж маань бол ирж байгаа бохир усаа 100 хувь цэвэрлэж чадахгүй 70 хувьтай ч юм уу цэвэрлээд Туул гол руу нийлүүлж байгаа. Ийм одоо хүндрэлтэй нөхцөл байдал байгаа. Тэгээд цаашидаа энэ чиглэлээр бид бүхэн сайжруулах үүднээс хэд хэдэн ажлууд хийгээд явж байгаа.

Нэгдүгээрт шинэ төв цэвэрлэх байгууламж баригдаж байгаа. Барилга

угсралтын ажил бол 60 орчим хувьтай явж байгаа. 2024 оны 8 дугаар сард энэ цэвэрлэх байгууламж маань ашиглалтад орох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Энэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орсноор хоногийн 250 мянга метр куб бохир усыг хүлээн авч, цэвэрлэж стандартын шаардлага хангасан байдлаар Туул гол руу нийлүүлэх, дахин ашиглах ийм нөхцөл байдал бүрдэнэ. Тэгээд энэ цэвэрлэх байгууламжийг байгуулахад байгуулж дууссаны дараа бид нар тэр цэвэрлэх байгууламж руу ирж байгаа бохир усыг стандартын шаардлага хангасан байдлаар цэвэрлэж, хүлээж авах ийм шаардлагатай байгаа. Ялангуяа энэ ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, энэ цэвэрлэх байгууламж руу ирж байгаа усыг дахин ашиглаж 3, 4 дүгээр цахилгаан станц руу нийлүүлэх Мянганы сорилтын сангийн 2 том төсөл буцалтгүй тусламжаар хэрэгжих шатдаа явж байгаа. Тэгээд энэ нэгдүгээрх нь бол ундны усны эх үүсвэрийг сайжруулна. Өнөөдөр Улаанбаатар хотын нөөцийг бол 2 дахин сайжруулах ийм төсөл байгаа.

Хоёрдугаарх нь энэ цэвэрлэх байгууламж руу ирж байгаа усыг буюу усны 1/4-ийг буюу хоногийн 50000 метр куб усыг дахин 3, 4 дүгээр цахилгаан станц руу ашиглах ийм төсөл байгаа. Тэгээд энэ төслийг Монгол Улсын Засгийн газар, Мянганы сорилтын сантай хамтран хэрэгжүүлж байгаа. 2 тал үүрэг хүлээсэн байдаг. Манай талаас ямар үүрэг хүлээсэн бэ гэхээр цэвэрлэх байгууламж руу ирж байгаа усыг ахуйн хэрэгцээний шаардлага хангасан ийм бохир усыг нийлүүлнэ гэдэг үүрэг хүлээсэн. Тэгсээр Улаанбаатар хотод байгаа нийтдээ бүх үйлдвэрүүдийн усыг бид нар хүлээж авах боломжгүй болж байгаа юм. Тэгээд энийгээ бид нар үүргээ хүлээгээд Мянганы сорилтын сантай, Америкийн Нэгдсэн Улстай тохирохын тулд энэ төл төлөвлөгөөг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдэг төлөвлөгөөгөө Засгийн газраар батлуул, батлуулсных нь дараа бид бүхэнд танилцуул гэдэг

үүргийг хүлээсэн. Үүний дагуу бид нар бол нийтдээ цэвэрлэх байгууламж руу ирж байгаа бохир усыг стандартын шаардлага хангасан байдлаар хэрхэн яаж зохион байгуулах вэ гэдэг 70 үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын хурлаар бол оруулж батлуулсан. Америкийн талтайгаа бас энийг тохирсон байгаа. Тэгээд энэ хэрэгжилтийг хангах салбар дундын ажлын хэсэг байгуулагдсан ажиллаж байгаа. Энэ дээр бол одоо энэ чиглэлээр хамтарч оролцдог Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, манай яам, Ус сувгийн удирдах газар, Усны газар, холбогдох холбоод гээд бүх байгууллагууд орсон ажлын хэсэг байгуулагдаад энэ 70 ажлаа төлөвлөгөө гаргаад, дүгнээд улирал бүр хуралдаад үүнийхээ хэрэгжилтийг хангаад явж байгаа. Тэгээд энэ цэвэрлэх байгууламж ирэх жил ашиглалтад орох нэгдүгээрт.

Хоёрдугаарт. Энэ Мянганы сорилтын сангийн 2 төсөл маань ингээд амжилттай хэрэгжээд дуусах юм бол ямар ч гэсэн Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэр бол ойрын хэдэн жилдээ бол айлтгүй. Эх үүсвэр талаасаа.

Хоёрдугаарх нь одоо эрүүл мэнд талаасаа бас айлтгүй.

Гуравдугаарх нь бол энэ цэвэрлэх байгууламж руу ирж байгаа бохир ус цэвэрлэгдээд Туул гол руу ашиглагдах байдал нь бол стандартын шаардлага хангасан байдлаар зохион байгуулж болно гэдэг ийм төлөвлөгөөтэй бид бүхэн ажиллаж байна. Товчхондоо мэдээлэл өгөхөд ийм байна.

Б.Энх-Амгалан: Золбоо сайдад баярлалаа. Энэ танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд байна уу. Асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Дараа нь би асуулт асууна. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр Нийслэлийн ундны усны эрүүл ахуй, аюулгүй байдал, чанартай холбоотой асуудал бол тулгамдсан асуудал болчихсон байгаа. Тэгэхээр би энэ яагаад энэ ундны усны эх үүсвэр газрууд дээр газар олголт хийгээд байдаг юм бэ. Энэ нийслэл Улаанбаатар хотоос энэ ажлыг хариуцаж байгаа хүмүүс байна уу. Би одоо бодитой болсон явдлыг л ярьж л даа. Одоо 10 хэдэн жилийн өмнө 2006, 2007 оны үед Буянт-Ухаагийн Спортын ордон гэж ярьдаг шүү дээ. Тэр ордныг барихаар Хятадын талаас Хятадын ард түмний тусламжаар баригдахаар болоод газрын асуудал шийдэгдээгүй, Хятадын талаас компаниуд нь ирчихсэн ингээд ийм байсан. Тэгээд бид нар Ерөнхийлөгч дээр тухайн үеийн хотын дарга, холбогдох хүмүүс цуглаад уулзаад газрын асуудлыг шийдэж өгөөч гээд. Бид бол төлөвлөхдөө одоо энэ презерь гэж хуучин ярьдаг байсан шүү дээ. Энэ урагшаа презерь гараад энэ Баянмонгол хороолол барьчихсан тэнд газар төлөвлөж байсан юм. Уг нь бол төв стадионоос зүүн тийш Баянзүрхийн гүүр хүртэл энэ бүсийг бол Нийслэлийн иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх спортын, биеийн тамирын бүс болгохоор ингэж төлөвлөөд, энэ хүрээндээ тэр Буянт-Ухаагийн ордны газрын асуудлыг тавьсан байхгүй юу. Үгүй ээ, тэгсэн чинь зэрэг нийслэлийн удирдлагууд, хүмүүс үгүй ээ, наана чинь ерөөсөө өгч болохгүй. Бүр халхай зуузай. Наадах чинь бүр Нийслэлийн иргэдийн цэвэр ундны эх үүсвэр, хамгаалалтын бүс гээд. Тэгээд хаана өгөх юм гэсэн чинь 22-ын товчооны цаана өгнө гэж байгаа юм. Үгүй ээ, тэгээд бүр ярьж ярьж байж арай гэж тэр Буянт-Ухаагийн тэнд нэг ийм газар өгөх болсон байхгүй юу даа. Зүгээр нэг жишээ л энэ. Гэтэл одоо нөгөө өгөхгүй айхтар газар гэж байсан чинь одоо тэрийг чинь бүр тэр чигээр нь Энхтайвангийн гүүрнээс зүүн тийш нь, баруун тийш нь ерөөсөө бүр одоо бүр зайгүй газар өгчихсөн байгаа шүү дээ.

Хоёрдугаарх нь бол одоо би энэ хойно зусланд Баянбулаг гээд тэнд байж байдаг. Тэгээд тэр чинь бол энэ Ерөнхийлөгч тэрбум мод хөтөлбөр зарлачихсан. Нийслэлийн ундны усны нэг том эх үүсвэр Сэлбэ голын цутгалт салбар булгууд байна шүү дээ. Баянбулаг гээд. Тэгээд тэнд ингээд газар өгөөд байдаг. Эрх мэдэлтэй ийм хүмүүс Нийслэлийн, Байгаль орчны яамны, өөр юу байдаг юм эрх мэдэлтэй хүн болгонд газар өгөөд одоо та нар хараарай. Би энэ Сумъяабазарыг аваачаад тэнд өөрийнхөө лайваар хийгээд олон түмэнд хүргэсэн. Ингээд одоо энийг нь шийднэ гээд ярьсан. Байгаль орчны яам танай нөхөд би удаа дараа тавьсан. Үгүй ээ, одоо эрх зүй нь ингээд болдоггүй юм. Ингээд газрыг Нийслэл, дүүргээс өгчихдөг юм. Байгаль орчны яам ингээд араас нь хөөцөлдөөд ингээд болдоггүй юм аа л гээд суугаад байна. Үгүй ээ, энэ чинь яагаад энэ хууль, эрх зүйн зохицуулалт юм хийгээд энэ асуудал дээр шийддэггүй юм бэ. Энэ чинь бэлээхэн байгаль өөрөө хэчнээн сая жилийнхээ явцад 100 мянган жилийнхээ явцад ингээд бий болгочихсон тэр тэрбум модыг чинь тарих гээд үйлээ үзээд байна шүү дээ. Гэтэл тэрийг нь талхлаад, сүйтгээд байдаг ийм юмаа яах юм бэ. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөх бололцоо байх уу, үгүй юү гэж.

Дараагийнх нь нэг юм бол намайг олон жил энэ Хэрлэнгийн усыг урагш нь Говь руу татуулахын эсрэг байсан гээд ингээд гүтгээд байдаг. Гэтэл энэ чинь бодит байдал дээр бол Хэрлэнгийн голынхоо өнөөгийн нөхцөл байдалд нь дүн шинжилгээ хийж, судалгаа дахиж хийе ээ гээд энэ судалгааг нь хийгээд, холбогдох байгаль орчны хуулиудад нь өөрчлөлт оруулаад, Монгол орны томоохон 20 гаруй гол мөрний сав газрын захиргааг нь байгуулаад ингээд энэ ажил чинь явж байгаа шүү дээ. Хөх морь төсөл.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Маш тодорхой асуулт асуулаа шүү. Хот байгуулалт хөгжлийн газрын дарга Ц.Тулга хаана

байна. Тулга дарга тийшээ суу. Та тэр 1 номерын микрофон дээр суу. Тэгээд хариул. Тэрний дараа нэмээд Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Батзориг байна уу. Батзориг дарга хариулна шүү. Ингээд та 2 наад асуудлуудаа яг хариулаадаг. Энэ Бат-Эрдэнэ гишүүний асууж байгаа асуулт бол маш тодорхой асуултууд байна шүү. Та нар хар даа. Одоогийн байдлаар Хот байгуулалтын мэдээллийн санд тусгагдсан 8 байршилд ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд 4053 аж ахуйн нэгжид 2389.9 га газар олголт хийгдсэн байна гэж байна. Ундны усны эх үүсвэр дээр шүү. Энийгээ маш тодорхой хариулна шүү. 1 номерын микрофоныг өгөөдөхье дөө. 2 нь асаад байгаа юм уу. 2 номер дээр суучих. Золбоо сайд солигдоод суучих. Энэ дээр Бат-Эрдэнэ сайд та нэмээд тодруулаад хариулаарай.

Ц.Тулга: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсээр 1980 оны Ардын депутатуудын Их Хурлын Гүйцэтгэх захиргааны 172 дугаар тогтоолоор анх тогтоосон байдаг. Үүний дараа Нийслэлийн Засаг даргын 2003 оны 95 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн газар доорх усны эх үүсвэрийн гадаад, дотоод мужийн хамгаалалтын бүсийг тогтоож мөрдөх дэглэмийг баталсан. Үүний дараа бол 2009 онд Нийслэлийн Засаг даргын 95 дугаар захирамжаар Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн тэжээлийн гадаад болон дотоод мужийн хамгаалалтын бүсийг бол 1, 2 дугаар хавсралтаараа тогтоосон. Хамгийн сүүлд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолоор эдгээр бүсийг бол шинэчилж тогтоосон байдаг юм. 2016 онд шинэчилж тогтоосон Иргэдийн Хурлын тогтоолоор тухайн хориглолт, хамгаалалтын бүсийн хэмжээ бол нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор

тухайн газарт газар, өмчилж, эзэмшиж байсан иргэд бол энэ хориглолт хамгаалалтын бүсэд ингээд хамрагдсан ийм байдалтай байдаг. Шинээр бол 2016 оноос хойш тухайн хориглолт, хамгаалалтын бүсэд шинээр газар олгох, барилга барих зөвшөөрлийг бол хориглосон байгаа. Одоогоор бол хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэгдсэн 4126 иргэний эзэмшиж байгаа газар, эндээс 2039 газар нь бол өмчилсөн газар, 2183 газар бол эзэмших эрхтэйгээр байгаа. Эдгээр иргэдийн өмчилсөн болон эзэмшиж байгаа газруудыг бол цаашид хориглолт, хамгаалалтын бүсээс шилжүүлэх энэ ажлыг бол Нийслэлийн хэмжээнд Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Дүүргүүдийн газрын албууд бол зохион байгуулаад ингээд ажиллаж байгаа. Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газрын тухайд бол хот байгуулалтын мэдээллийн санг байнгын мөрдөж байгаа дүрэм журмын дагуу барилга, байгууламжийг бол бүртгэж ажилладаг байгаа. Одоогоор бол тухайн хориглолт, хязгаарлалтын бүсэд шинээр бол газар олгох, барилга байгууламжийн зөвшөөрөл олгох ажиллагаа бол хийгдэхгүй байгаа.

Б.Энх-Амгалан: Чи бүүр нэг тодорхой хариулаач. Энэ цэвэрлэх байгууламжийн бүсэд 723 нэгж талбарт 1137.7 га газар олгосны дотор Дүүргийн Засаг даргын захирамжаар 141.2 га газар олгогджээ гэж байна. Энийгээ яаж цэгцлэх юм. 1 дэх асуудал нь.

Сая гишүүн бол маш тодорхой асуугаад байна шүү дээ. Энэ ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд 4053 аж ахуйн нэгжид 2389.9 га газар олгогджээ. Эд нарыгаа яаж цэгцлэх юм бэ л гэж асуугаад байна шүү дээ. Олгогдоогүй ээ. Одоо 2016 оноос хойш олгогдоогүй гэсэн. Одоо энэ Гачууртын чинь амаар бол зөндөө олгогдчихсон байна лээ шүү дээ. Тэр Туул гол руу чинь бүр шахаад шахаад барьчихсан. Би танай дарга нарт зургийг

нь явуулсан. Бүр голынхоо эрэг дээр юун 500 метр бараг эрэг дээр нь байшин бариад хаячихсан, одоо ч барьж л байна. Та нар тэрүүгээр яваад үзвэл. Тэгэхээр ийм юмнууд зөндөө байх юм. Тэгээд энийгээ яах юм бэ гээд л Бат-Эрдэнэ гишүүн асуугаад байна шүү дээ. Тэр дээр нэг тодорхой хариулаадхаач. 2 номерын микрофон Тулга дарга хариулъя. Нэмж тэр газрын албанаас хүн байна уу. Газрын албаныхан нэмж хариулаарай.

Ц.Тулга: Газар олголттой холбоотой асуудлыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас бас тодорхой хариулах байх.

Б.Энх-Амгалан: Нэр, албан тушаалаа хэлж байгаад хариулъя. 2 номер дээр суугаад шууд хариулаадахъя.

Ж.Гал: Сайн байна уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтсийн мэргэжилтэн Гал байна. Сая Тулга дарга хэлсэн. Тухайн 2016 оны 50 дугаар тогтоолоор батлахдаа хил хязгаарт бол нэлээн их өөрчлөлт орсон. Одоо энэ өмчилсөн 2000 гаруй айл нь бараг энэ Яармагийн дэнжийн хэсгийн ихэнх айлууд өмчлөлд бас орсон байгаа. Төвийн хэсэг дээр бол Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, мөн 2 дугаар цахилгаан станцын орчим бол тэр чигээрээ эх үүсвэрийн хамгаалалтын зурваст нэмэгдсэнтэй холбогдуулан хамгаалалтын бүсэд өртчихсөн байгаа. Тэгэхээр 2016 онд Иргэдийн Хурлын тогтоол гарахаас өмнө бол энэ тухайн байршилүүд нь бол ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд ороогүйгээр байсан. 2009 оны 95 дугаар тогтоолоор. Сая тогтоол нэмэгдэж батлагдахдаа талбайн хэмжээ нь нэлээн томорч батлагдсантай холбоотойгоор энэ айлууд бол орчихсон байгаа. Бүр 1980-аад он, 1970-аад оны үед суурьшсан байсан иргэд болон тухайн үед баригдсан орон сууц барилга байгууламжууд, үйлдвэрийн газрууд энэ хамгаалалтын

бүс дотор орчихсон байгаа гэж ойлгож болно.

Б.Энх-Амгалан: Бат-Эрдэнэ сайд тодруулаад хариулах уу. 3 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Нийслэл, дүүргээс газар олголттой хийгдэж байгаа. Бодит юмыг бодитоор нь бид нар ярих ёстой. Ялангуяа дүүргүүд дээр бол газар олголттой холбоотой, тэр Сэлбэ голтой холбоотой асуудлууд, Дунд голтой холбоотой асуудлууд, Туул голтой холбоотой асуудлууд ч байгаа. Энэ бол өнөөдрийн байгаа яг бодит үнэн. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас бол Туул голын сав газрын дагуух ашиглагдаж байгаа ялангуяа тусгай хамгаалалттай бүс нутагт хамаарч байгаа хэсгүүдийг бол ээлж дараатайгаар бид нар цуцалж байгаа. Нөгөө талдаа онцгой хамгаалалтын бүсийг тэлэх ийм зарчмыг бол барьж ажиллаж байгаа. Ялангуяа Бат-Эрдэнэ гишүүний хэлдэг Сэлбэ голтой холбоо бүхий асуудал бол өнгөрсөн хавар, намар хөндөгдсөн асуудлууд. Тэнд бол мод сүйтгэж, Сэлбэ голын дэргэд бол байшин барих ийм асуудлууд бол өнөөдөр ч гэсэн хөндөгдсөөр яваа. Нийслэл, дүүргээс бол энэ захирамжуудаа яаралтай цуцлахыг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас байнга шаардаж байгаа. Тухайлах юм бол усан паркттай холбоо бүхий асуудал 2022 оны 4 сарын 25-ны өдөр тухайн барилга 3 давхар, 4 давхар дээрээ явж байхад Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас бол Дунд голын сав газарт орж байгаа учраас энэ захирамжаа, олгосон зөвшөөрлөө цуцал гэдэг ийм бичгийг бол Нийслэлийн Засаг даргад явуулсан байдаг. Өнөөдрийг хүртэл хариу байхгүй байгаа. Өнөөдөр 2023 оны 4 сарын 18-ны өдөр болж байна. Түрүүний миний хэлдэг Хан хиллстэй холбоо бүхий асуудлууд гэх мэтчилнээр ингээд асуудлууд бол яалт ч

байхгүй Улаанбаатар хотын эргэн тойронд бол байгаа. Энийг бол хууль, эрх зүйн орчинд тодорхой хэмжээний хамгаалалтын бүсийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоодог энэ зарчим дээрээ бид нар эргэж анхаарахгүй бол бас болохгүй байгаа гэж бид нар харж байгаа. Энэ ч утгаараа бид нар Улсын ерөнхий прокурорт хамтран ажиллах саналыг бол явуулсан. Хүсэлт бол энэ Ойн сан, Усан сан бүхий газрууд дээр хуулийн хэрэгжилтийг хангуулах Байгаль орчин, аялал жуулчлалын яам өнөөдөр нийслэл, аймаг, сум, дүүргүүдэд албан бичиг явуулж хэрэгжилтийг хангуулахаар хандаж байгаа боловч огт хангагдахгүй байгаа учраас бид нар Улсын ерөнхий прокурорт энэ асуудлаар хандаж байгаа гэсэн үг.

Хөх морьтой холбоотой асуудал байна. Орхон-Онги бол 2020 оны ТЭЗҮ-тэй, Хэрлэн тооно бол 2014 оны ТЭЗҮ-тэй. Хэрлэн тооныг бид нар 2014 оны ТЭЗҮ шинэчлэгдэх шаардлагатай гэж бид нар харж байгаа. 2020 оны ТЭЗҮ-тэй Орхон-Онгийн төсөл дээр бол Эдийн засаг, хөгжлийн яамтай бид нар энэ асуудлыг яриад явж байгаа. Зураг төсөл дээр 6.8 тэрбум төгрөг шаардлагатай байгаа. 2022 онд бол энийг мөн хөөцөлдөөд улсын төсөв дээр оруулж чадаагүй. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит бас компаниас санал ирсэн. Түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр нийт хөрөнгө оруулалтыг бол бүгдийг нь хийе гэдэг ийм санал бол ирсэн. Тэгээд уг саналыг бол бид нар эхний ээлжид дотооддоо шийдвэрлэх шаардлагатай гэдэг утга агуулгын хүрээнд бол Эдийн засаг, хөгжлийн яамтай энэ жил ядаж гарах ёстой тодорхой зураг төслийн мөнгөнүүдийг гаргачих боломж байгаа юу гэдэг тал дээр бол Хүрэлбаатар сайдтай бид нар энийгээ яриад явж байгаа. Энэ дээр бол тодорхой төсвийг бол гаргаж оруулж өгнө гэдгээ бас илэрхийлсэн. Орхон-Онги төсөл хэрэгжсэнээр өмнийн говийн энэ устай холбоо бүхий асуудлууд бол шийдвэрлэгдэх ёстой. Өнөөдрийн байгаа

ундны усны хэрэглээ 2030 он гэхэд өмнийн говьд бол давах нийлүүлэлтээ давах ийм хэмжээнд байгаа. Тэгэхээр бид нар Орхон-Онгийг нэн яаралтай түвшинд ойрын хугацаанд шийдвэрлэхгүй бол өмнийн говь бол 2030 он гэхэд тодорхой усны хомсдолд орно гэдэг ийм тооцоо судалгааг бол усны агентлагаас бол бид нарт бас гаргаж өгч байгаа.

Б.Энх-Амгалан: Тодруулах уу. Бат-Эрдэнэ гишүүн 1 минут нэмж тодруулъя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Би одоо аль болохоор нуришихгүй, бодитой болсон явдлыг баримттай л ингээд л хэлээд байгаа юм даа. Хүн уг нь ойлговол ойлгохоор юм хэлээд байх шиг байна. Тодорхой хариултуудыг энэ ажил хариуцаж байгаа хүмүүс өгөхгүй байна. Шаардлага өгөөд байдаг тэгээд шаардлага биелэхгүй байгаагийн цаад талын шалтгаан нь юу юм бэ. Хууль өөрчлөх шаардлагатай бол Их Хурал руу хуулиа оруулаач ээ. Бүр шаардлагатай бол яаралтай горимоор оруулаад, хэлэлцүүлээд батлах Их Хурлын эрх зүйн ийм орчин байгаа шүү дээ.

Хоёрдугаарт нэг асуух гээд байгаа юм бол манай Нийслэлийн иргэд энэ төв суурин газрын иргэд маань ер нь хуучин бол крантнаасаа ус аваад л уудаг байсан. Энэ спортын ордонд залуу хүүхдүүд бид шигшээ багийн тамирчид байхад тэгдэг л байсан. Одоо тийм хэмжээний эрүүл ахуйн шаардлага хангаж байна уу, үгүй юү. Энэ дээр тодорхой хариулт өгөх бололцоо байна уу.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ. Усны газар хариулах уу. Ус сувгийн удирдах газар Төрхүү дарга урагшаа суу. 2 Номерын микрофон дээр Ус сувгийн удирдах газрын дарга Төрхүү хариулъя. 2 номерын микрофоныг өгье.

Ц.Төрхүү: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариу хэлье. Улаанбаатар

хотод бол нийтдээ 7 эх үүсвэр байдаг. 7 эх үүсвэр, 3 жижиг эх үүсвэр тэгээд нийтдээ 10 эх үүсвэрээс Улаанбаатар хотын стандарт хангачихсан унд ахуйн усаар хангагдаж байдаг. Өнөөдөр бол бид бүгд тэр эх үүсвэрүүдийг Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар хариуцаж ажиллаж байдаг. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын зүгээс бол хоногт гарч байгаа бүх эх үүсвэр дээрээс гарч байгаа усан дээрээс дээжтэй явж байдаг. Мөн бид бүхэн бол яг Улаанбаатар хотын эх үүсвэрүүд бол баталгаатай гэдгийг бол энэ дээр бол албан ёсны бас хэлье гэж бодож байгаа юм. Албан ёсоор хариуцаж байгаа хүний хувьд. Харин цаашилаад шугам сүлжээнд асуудлууд байгаад байна. Шугам сүлжээд энэ хувийн орон сууц барьж байгаа нөхөд маань стандартад нийцсэн шугам сүлжээ тавьж ажиллаж байна уу, ажиллахгүй байгаа юу гэдэг асуудал байгаад байгаа юм. Мөн энэ стандартад нийцсэн шугам сүлжээнүүдийг энэ босоо шугамуудыг энэ байшин хороололд шинээр барьж байгаа байшин хороололд бас стандартад нийцсэн шугам сүлжээ барьж байна уу, үгүй юү гэдэг бас 1 стандарт байгаад байгаа юм. Сүүлийн үед энэ Яармаг дээр зэвтэй бас гараад байгаад байгаа юм. Тэгээд энийг бол нэлээн их бид бүхэн бол бас шинжлэн судлуулсан. Яармаг дээр барьж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд эхний ээлжид бол Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрууд ийм ус түгээгээд байна гэдгийг ярьсан. Бид нар 3 удаа Солонгос руу явуулж шинжлүүлсэн. Ус сувгийн удирдах газар өөрөө Монгол улсын хамгийн том лабораторитой байгууллага байгаа уснаа. Энэ лабораторийн дээжид итгэхгүйгээр байдгаас үүдэж 3 удаа гадагшаа явуулж шинжилгээ, судалгаа бид бүхэн эх үүсвэрүүд дээр хийлгүүлсэн. Бүгд бол стандартад нийцсэн гэж гарсан. Мөн бид бүхэн юунаас болоод байгаа гэдгийг бас олсон. Энэ бол Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба дээр ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгийн

хүрээнд ажил маань явагдаж хийгдэж, 1 талдаа гарсан байж байгаа. Юу вэ гэхээр дамжуулж байгаа шугам, сүлжээний насжилт болон дамжуулж байгаа шугам сүлжээний стандартын бус гэдэг юман дээрээс бол зэв гэдэг юм гарч ирж байгааг бол тогтоочихсон байж байгаа. Энийг бид бүхэн энэ 5 сараас эхлээд бас янзлах гээд төсөв хөрөнгийнх нь асуудлыг 1 талдаа бас гаргаад явж байгаа. Өнөөдөр энд Улаанбаатар хотын менежер байхгүй болохоор би нөгөө ажлын хэсэгт нь өөрөө байдаг хүний хувьд бол хэлж байгаа юм. Тэрнээс биш Улаанбаатар хотын менежер байсан бол бас нэлээн дэлгэрэнгүй ярих байсан болов уу гэж би бодож байна. Хэрвээ энэ аж ахуйн нэгж байгууллагууд, энэ хувь хүмүүс Улаанбаатар хотын ундны усанд итгэхгүй байх юм бол зөвхөн Яармагийн бүс хавь зэвтэй гарахгүй ээ. Тэр чигтээ 120, Хан-Уул дүүрэг, Баянгол дүүргийн 3, 4 дүгээр хороолол тэр чигтээ зэвтэй гарна. Яагаад гэвэл 1 эх үүсвэрээс гарч байдаг. Энэ нь үйлдвэрийн эх үүсвэрээс энэ уснууд гарч байдаг. Өнөөдөр Яармаг дээр бол нийтдээ 380 гаруй орон сууцууд баригдсан байна. 380 гаруй орон сууцнаас 30 хэдэн орон сууц одоо зэвтэй гарч байна гэж гарч ирж байгаа. Тэгээд энэ тоног төхөөрөмжүүд болон энэ шугам сүлжээний асуудлуудыг бид бүхэн нэг талдаа гаргах гээд Улаанбаатар хот дээр энэ ажлын хэсэг байгууллагуудаа хийгдээд ер нь үр дүн гарч байгаа гэдгийг бас энд хэлье гэж бодож байна. Тэгээд өнөөдөр Улаанбаатар хотын 10 эх үүсвэр бол чанарын түвшинд байгаа гэдгийг бас энд албан ёсоор хэлье гэж бодож байна.

Б.Энх-Амгалан: Бат-Амгалан гишүүн асуултаа асууя. Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Э.Бат-Амгалан: Өнөөдөр уг нь их энэ том сэдэв л дээ. Усны сэдэв Монгол Улсын ч биш Дэлхийн хэмжээний бараг 1 номерын асуудал болчихоод байна. 21 дүгээр зуун ерөөсөө л усны дайн болох

ийм л зуун гэж бүх л эрдэмтэн судлаач бүх мэдээллийн хэрэгслээр явж байгаа. Өнөөдөр бол зүгээр мэдээллийг дутуу авч байна гэж ойлгож байна. Байгаль орчны сайд, Барилгын сайд дэд сайд орж ирж. Энэ чинь өнөөдрийн сэдэв хүртэл ойлгомжтой л байна шүү дээ. Усны нөөц, аюулгүй байдал гээд. Энэ чиглэл дээр юу ч ярьсангүй. Нийслэлээс ямар ч дарга тайлан мэдээлэл тавьсангүй. Тэгээд маш олон дарга нар орж ирээд суучихсан. Мэдээлэл бол их дутмаг муу авсан гэж нэгдүгээрт ойлгож байна.

Хоёрдугаарт би ийм хэдэн юм асууя. 2 шатлалын л юм асууя гэж бодож байгаа юм. Нийслэлийн энэ тайлан мэдээнд мэдээ сонсоогүй. Тэгээд ер нь Улаанбаатар хотод хэдэн энэ булаг, шанд, рашаан байсан юм бэ. Одоо хэд үлдчихээд байгаа юм бэ. Хамгаалалтад авсан юмнууд юу байна вэ. Миний мэдэхээр тэр хуучин Дондогдуламын рашаан гээд байсан. Энэ ширгээд алга болсон. Нөгөө хүүхэд байхад их сайхан ийм рашаан байдаг байсан. Байхгүй болсон.

2 дугаар асуудал энэ Баянзүрх дүүргийн миний сонгогдсон тойргийн Дарь-Эхийн орчим энэ Дамбадаржаагийн рашаан гээд байгаа. 2005 онд орон нутгаас төсөв гаргуулж, жосохон хамгаалалтад авсан. Тэгээд өнөөдөр бол ерөөсөө ямар ч тийм хамгаалалт байхгүй, бохирдоод, ширгээд дуусчихдаг. Бид нар усны нөөц аюулгүй байдал ярих юм бол тэр гарч байгаа ундарга нөгөө саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэг шиг тэр ундарга энэ хамгаалалтад авах энэ асуудлууд. Энэ дээр нэг тоймтой хариу өгөөдхөөч. Би салбарын хүн биш учраас сайн мэдэхгүй байна. Хаана энэ хамгаалалтад авах асуудлуудыг ярих ёстой юм бид нар. Энэ асуудал.

2 дугаар асуудал энэ Монгол Улсын хэмжээнд 10 гол дээр 33 байришилд бас усны нөөц хуримтлуулах ийм усан сан хийх боломжтой гэж мэдээлэл авсан. Тэгээд энэ мэдээлэл харамсалтай нь

бараг сүүлийн 80-аад оноос хойш яригдаад байдаг. Улаанбаатар хотын Туул голыг дагасан Туул голын усны сан байгуулах, барьж байгуулах тэрний голын урсац, голдирол бүгдийг хамгаалаад аваад явах энэ боломж бололцоотой Туул голын усны сан. Энэ асуудал ер нь ямар шатад яригдаж байгаа юм бэ. Энийг хэн нь хариуцаж хийх ёстой юм бэ. Тэгээд одоо Алсын хараа 2050 дээр хүртэл байгаа шүү дээ. Хөх морь төсөл гээд л түрүүн Бат-Эрдэнэ гишүүн асуугаад хариулсан хүн байсангүй. Тэгээд би бол 1 л юмыг харж байгаа юм. Энэ төрийн байгууллагууд маань зарим юмыг уялдаа холбоотой хоорондоо их ойлголцолтой ингэж ажиллахгүй бол үнэхээрийн хүнд түвшинд бид нар сонсдог болдог, та нар нэг тайлан тавьдаг. Тэгээд хэрэгждэг юм байхгүй. Нэг хурал хийгээд л гардаг. Тэгээд бие бие рүүгээ энэ нийслэлийнхэн тэр орон нутаг нь тэгдэг гээд сайд нь яриад сууж байдаг. Бусад нөгөө нөхөд нь хариулах ийм боломж бололцоо байхгүй ингээд л явж байгаа шүү дээ. Дээрээс нь би бас 1 юм нэмээд асууя гэж бодож байна. Одоо энэ Үндэсний цэцэрлэгт хүрээлэн гээд 2007, 2008 оноос Улаанбаатар хотод энэ иргэдийн ирдэг ганц том сайхан цэцэрлэгт хүрээлэнтэй болчихлоо шүү дээ. Энэ бас ундны усны эх үүсвэр дээр байсан юм. Би анхных нь орлогч даргаар бас Саранчимэг гишүүн бид 2 хамт ажиллаж явж байсан юм. Одоо Баянзүрх дүүрэг дээр олон улсын цэцэрлэгт хүрээлэн гээд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй ер нь хэмжээ дамжаагаараа ойролцоо ийм юм хийх гээд ингэдэг бүх шатандаа гацчихсан. Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид бүрэн эрхийнхээ хуульд заасны дагуу шийдвэр гаргаад явдаг. Нийслэл дээр Байгаль орчны газар, Ус суваг, Усны газар энэ Газрын алба гээд ингээд бүх шатандаа гацчихсан байгаа. Тэгсэн мөртөө сая.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ. Гараа өргөөд. Тэгвэл 2 номерын

микрофон. Нэрээ хэлээд албан тушаалаа хэлээд тэгээд хариултаа өгье.

О.Тэмүүжин: Нийслэлийн Байгаль орчны газрын Ойн хэлтсийн дарга Тэмүүжин. Нийслэлийн нутаг дэвсгэрт 2021 онд гадаргын усны тоо бүртгэлийг Туул голын сав газраар захирахтай хамтарч хийсэн байдаг. Энд бол нийслэлийн нутаг дэвсгэрт 227 булаг шанд бүртгэгдсэн. 70 гаруй гол горхи энд хамгаалалтын бүс тогтоогоод гол горхи байж байгаа. 2016 оны 50 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын А/139 дүгээр захирамж гарсан. Энэ захирамжийн ажлын хүрээнд бид бол хамгаалалтын бүс тогтоогдоогүй бүлэг шанд, гол горхийг хамгаалалтын бүс тогтоох ажлыг үе шаттайгаар хийж байгаа. Энэ ажлын хүрээнд Сэлбэ голын эх дээд эхэндээ хүртэл хамгаалалтын бүс тогтоодог байсан. Энийг нь бас нэмж оруулж байгаа. Мөн адил Улиастай гол эхийг бас оруулах ажлуудыг бас хийж байгаа. Энэ ажлуудыг хийж байгаа.

Б.Энх-Амгалан: Нэмж тодруулах уу.

О.Тэмүүжин: Мөн адил нэмэлт тайлбар. Байгаль орчны сайдаас чиглэл ирүүлсний дагуу нийслэлийн нутаг дэвсгэр, Туул гол түүний цутгал голууд бол хөв цөөрөм байгуулах ажлыг Байгаль орчны сайдаас чиглэл ирүүлсний дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт 3 байришил эхний ээлжид хөв цөөрөм байгуулчаад байна. 2023 ондоо бол Дэндийн голд 8000 метр куб шоо метр ус хөв цөөрөм байгуулах ажлыг бас хийж байгаа.

Б.Энх-Амгалан: Бат-Амгалан гишүүн нэмж тодруулъя. Бат-Амгалан гишүүнд 1 минут нэмж өгье.

Э.Бат-Амгалан: Энэ хариултаа бас авч чадсангүй л дээ. Жишээ нь тэр Дамбадаржаагийн рашааныг хамгаалалтад авахгүй юм уу, хаана авдаг юм бэ. Нийслэлийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурал дээр одоо шийдвэр гаргах ёстой юм уу. Орон нутгийн эрх хэмжээ юм уу. Байгаль орчны яам хариуцдаг юм уу гээд энийгээ нэгдүгээрт ярьчихмаар байна. Тэр 8000 метр куб гэдгийг чинь би бол сайн мэдэхгүй. Хэр том юм, жижиг юм. Хэдий хэмжээний айл өрх хуримтлал үүсдэг юм. Зүгээр ер нь миний ойлгож байгаагаар Туул голын усан сан гээд нэлээн томоохон юм улс үндэсний хэмжээнд энэ яамтайгаа, Засгийн газартайгаа болбол энэ Их Хурал дээр дэмжлэг аваад ингээд нийслэлтэйгээ хамтраад байгуулах ёстой л гэдэг юм ярьж байгаа байхгүй юу. 8000 гэдэг нь одоо хэдэн хэмжээтэй ч юм мэдэхгүй байна. Тэгээд дээрээс нь би тэр түрүүний юуг нэмээд бас хэлчихье гэж бодож байна.

Тэр олон улсын цэцэрлэгт хүрээлэн гээд Баянзүрх дүүрэг дээр хийх гэж байгаа энэ том цэцэрлэгт хүрээлэнгийн асуудлыг та нар минь, дарга нар Баянзүрх дүүрэг очиж ажиллаад, шийдэж өгөөч ээ. Байгаль орчны сайд.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Хариулъя. 2 номерын микрофон.

О.Тэмүүжин: Дамбадаржаагийн булгийн хувьд бол дүүрэг өөрийн шийдвэрээр орон нутагт тусгай хамгаалалтад авах бүрэн боломжтой. Энэ талаар бас дүүргийн холбогдох албан тушаалтантай санал солилцоод явж байгаа. Бас саналыг орон нутгаас авах бүрэн боломжтой гэдэг утгаараа.

Б.Энх-Амгалан: Стандарт хэмжилзүйн газар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лаборатори 107 тоотгоор энэ хүнсний усны эрүүл ахуйн асуудлаар юм ирүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн газар бас Монгол Улсын ундны усны чанарын судалгааны дүн мэдээгээ ирүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн газар яг энэ дүн мэдээгээ бас энд танилцуулаадхаарай. Улаанбаатар хот Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч

агентлаг Хот байгуулалт, хөгжлийн газар 042620 тоот бичгээ ирүүлсэн. Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн. Хот байгуулалт, хөгжлийн газраас ирсэн. Нийслэлийн Байгаль орчны газраас ирсэн. Байгаль орчны яамнаас ирсэн. Дээр нь бот Стандарт хэмжил зүйн үндэсний төвөөс ирсэн. Мөн Барилга, хот байгуулалтын яамнаас гээд. Ингээд энэ устай холбоотой, ундны устай холбоотой, ундны усны эрүүл ахуйтай холбоотой нэлээн олон бичгүүд ирээд гишүүдэд тараагдчихсан. Цаашидаа бол энэ асуудлаар бол мэргэжлийн Байнгын хороо болох Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн байнгын хороотой хамтарч бас хэлэлцүүлэг хийхээр яригдаж байгаа. Өнөөдөр ундны усны аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой асуудлаар бид нар ярьж байгаа юм. Тийм учраас энэ дээр бол нэлээн тодорхой хариултуудыг мэргэжлийн хүмүүс нь өгөөрэй гэдэг талаас нь хэлье. Нийгмийн эрүүл мэндийн газрынхан энэ усны чанарын судалгааныхаа дүнг танилцуулаадхаач. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний үндэсний төвөөс 2 номерын микрофон дээр суугаад танилцуулаадах. Тэрний дараа наадах чинь бас нэлээн юмнууд тодорхой болно. 2 номерын микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд.

С.Өнөрсайхан: Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Өнөрсайхан байна. Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Бид нар жил болгон бол хяналтад явдаг. Миний энэ тоо баримтын дараа бол манай Эрүүл мэндийн яамны харьяа Мэргэжлийн хяналтын газраас хийсэн дүгнэлтүүдээ бол бас мөн танилцуулна. Бид нарт байж байгаагаар бол энэ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл болон Шинжлэх ухааны академи хамтран Монгол Улсын ундны усны чанарын судалгааг бол 21 аймгийн 360 сум, суурин газар, Улаанбаатар хотын 9 дүүрэг, төмөр замын дагуух 128 өртөө зөрлөг, суурины гүний худаг, ус түгээх байр зэрэг төв суурин газрын ундны

ахуйд хэрэглэгдэж байгаа 3582 уст цэгийн сорьцод ерөнхий физик, хими, бичил элемент, бичил амь судлал, цацрагийн аюулгүйн 88 үзүүлэлтээр бол шинжилгээг хийж үзсэн байгаа. Тоо баримт бол манайд байгаа. Энэ дээр бол судалгаанд хамрагдсан усны цэгүүдээс унданд хэрэглэх боломжгүй нь 151, нэмэлт төхөөрөмж суурилуулах шаардлагатай 606, нэмэлт төхөөрөмж суурилуулж халдваргүйжүүлэлт хийх шаардлагатай 296, Ариутгал халдваргүйжүүлэгч хийх буюу хэт ягаан туяа хлоржуулах аргаар ариутгал халдваргүйжүүлэлт хийж дахин шинжилгээнд хамруулсан тохиолдолд унданд хэрэглэх шаардлагатай 313, унданд шууд хэрэглэх боломжтой 2216 ус цэгүүд байна гэсэн мэдээлэл буюу 36 боть судалгааны тоо баримтууд бол бид нарт ирсэн. Үүгээр бид нар мэдээллийн сан үүсгээд газрын зураглал хийгээд ажиллаж байгаа. Мөн манай Сүнчин дарга энэ байнга манай дээр хяналтад явж байгаа өдөр тутам, сар, улирлаар хийж байгаа судалгааны усны цэгүүд дээр хийсэн судалгааны дүнгүүдээс хэлье хэлэх байх.

Б.Энх-Амгалан: Нэмээд 2 номерын микрофон хариулчих. Нэр, албан тушаалаа хэлээд тэгээд хариулчихъя.

С.Сүнчин: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар. Манай Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газарт мэргэжлийн хяналтад байсан хуучин эрүүл мэндийн хяналт шалгалт шилжин очсон байгаа. Энэ дундаа болохоороо эрүүл ахуй халдвар, хамгааллын хяналт хийгдээд явдаг. Өнөөдрийн яригдаж байгаа энэ хүн амын ундны усны асуудлаар бол хүн амын ундны усны тогтолцооны эрүүл ахуйн нөхцөл, усны чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4, Хот суурины усан хангамж ариутгах татуурга ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйл, Хүрээлэн буй орчин, ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар,

аюулгүй байдлын үнэлгээ, MNS 09002018 гэсэн стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор бид нар жил болгон энэ төлөвлөгөөт шинжилгээ хяналтыг бол хийж авдаг. Энэ дээр болохоороо нийслэл аймгуудын нийт төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрүүд дээр хяналт шалгалтыг бол хийдэг юм. Ингэхдээ бол нийтдээ энэ хуучин манай одоо Стандартчилал хэмжилзүйн газар байж байгаа үндэсний аюулгүй байдлын лавлагаа лабораторид нийтдээ 23, нийслэлийн мэргэжлийн хяналтын хуучнаар бол лабораторид 9, аймгуудын мэргэжлийн хяналтын лабораторид хуучнаар 6-11 үзүүлэлтээр химийн шинжилгээ, бүх лабораторид 3 төрлийн нян судлалын шинжилгээг бол хийж, жил болгон энэ мэдээллээ холбогдох яам, агентлагуудад хүргэж ажилладаг байх нь. Энэ сүүлийн 2021 онд энэ нян судлалын шинжилгээгээр нийслэл Улаанбаатар хотод бол нян судлалын шинжилгээгээр ерөнхий нянгийн тоо 3.6 хувиар их гарсан. Дээрээс нь эквивалент мөн 2021 онд 2.5 хувиар зөвшөөрөх дээд хэмжээнээс бол, зөвшөөрөх дээд хэмжээ биш ер нь 2.5 хувьд нь бол илэрсэн байгаа нийт шинжилгээ. Ерөнхийдөө энэ Салбарын хяналтын газраас бол энэ аймаг, нийслэлийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт дунджаар жил болгон 1500 орчим шинжилгээний дээж аваад, энэ дээр дурдсан холбогдох лабораториудад өгч шинжлүүлдэг. Энэ шинжилгээний дүн дээр жишээ нь усны хатуулаг нийслэл Улаанбаатарын хувьд бол хүн амын ундны усны дээд ба “А” эх үүсвэрт 08 микрограмм эквивалент литр зөөлөн “Б” эх үүсвэрт хатуувтар, “В” эх үүсвэрт бол хатуувтар, Гачууртын эх үүсвэрт бол маш зөөлөн ийм усны ангилалд бол энэ хатуулгийн юугаараа бол тогтоож байна. Үүний дагуу бол бид нар энэ хатуулгыг тогтоохын тулд холбогдох бүх дүрст нөгөө химийн элементүүд, кальци, магни, төмөр, сульфатыг бол ингээд үзээд явдаг байгаа. Түрүүн бас дээр дурдсан яг нөгөө крантнаас гарч байгаа ундны эх үүсвэртэй холбоотой зэв бохирдол ихтэй

байгаа энэ асуудал бол Манай нийслэл Улаанбаатарын энэ төмрийн агууламж бол ерөнхийдөө стандартын шаардлагыг хангаж байгаа боловч энэ нөгөө барилга байгууламжийн ус түгээх шугам, сүлжээний насжилттай холбоотой. Өөрөөр хэлбэл одоо Улаанбаатар хотод хэрэглэгдэж байгаа энэ ус хангамжийн сүлжээ бол үндсэндээ 5 жилээс 45 жил түүнээс дээш жил ашиглагдсан ийм систем байгаа. Энэ дээр бол бохирдол бас нэлээдгүй их гардаг. Хамгийн гол энэ ундны усны эх крантнаас гарч байгаа, хэрэглэгчээс гарч байгаа ундны ус бүр дээр гарч байгаа бохирдол нь юу байна вэ гэхээр одоо та бүхэн бас мэдэж байгаа Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны энэ олон хотхонууд байгаа. Эд нар маань бол бүгдээрээ дандаа хэсгийн гүний худгаас бол усан хангамжаа авдаг. Энэ хэсгийн гүний худгийн.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: 1 минут нэмээд өгчихье. Тодорхой, товч хариулаарай. 2 номер.

С.Сүнчин: Эрүүл ахуй хамгаалалтын бүсээ тогтоогоогүйгээр тухайн худаг дээрээ барилгажилт хийгдээгүй, мөн тэр хамгаалалтын бүсэд бол бас бус янз бүрийн үйл ажиллагаа явуулдаг ийм барилга, байгууламж баригдсан бохирдол ихтэй ийм асуудлууд байж байгаа. Энэ сүүлийн 11 жилийн 2002-2019 оны нийт хугацаанд ундны усны аюулгүй байдал алдагдсаны улмаас нийтдээ 11 удаагийн ийм дэгдэлт гарсан байгаа. Энэ дээр нь манай тухайн үед бол Мэргэжлийн хяналтын байгууллагын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын байцаагч нар ажиллаж байсан. Энэ 19 дэгдэлттэй холбоотой 939 гаруй хүн өвчлөлд өртөөд, 106 хүн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан байгаа. Энэ дагуу ингээд харахаар бол та бүхэн хамгийн сүүлд мэдэж байгаа. 2019 онд нийт 377 хүн энэ усны бохирдолтой холбоотойгоор эрсдэлд ороод, үүнээс 48 нь бол эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Баттөмөр гишүүний асуулт дээр нэмээд хариулчхаарай. Баттөмөр гишүүн асуулт асууя.

Б.Баттөмөр: Нэгдсэн Үндэсний Байгууллага, Дэлхийн байгаль хамгаалах байгууллагаас гаргаж байгаа мэдээллээр бол 21 дүгээр зууны томоохон тулгамдсан асуудлын нэг нь бол асуудлууд дотор энэ цэвэр усны асуудал бол үнэхээр их чухал байр суурь эзэлж байгаа. Анхааруулга өгч байгаа. Цэвэр усаа хэмнэлттэй зарцуулах, олон дахин ашиглах, цэвэр усыг ямар нэгэн байдлаар ашигласан усыг буцаж ашиглах чиглэлээр их олон асуудлуудыг гаргаж ирж тавьж байгаа шүү дээ. Ер нь үндсэндээ 2030 оноос эхлээд энэ цэвэр усны асуудал маш хүнд байдалд орно гэж. Ялангуяа энэ Арабын орнуудад бол 1 литр ус бол 1 литр бензинээс илүү үнэтэй байгаа шүү дээ. Та бүгд мэдэж байгаа. Тэгээд бид бол Байгаль, Дэлхийгээс өгөгдсөн нь их сайхан өгөгдөлтэй. Харамсалтай нь бол Монгол Улсын нийт усны гол мөрний бараг 80 хэдэн хувь нь гадагшаа урсаад явчихдаг гэж байгаа. Нийт дэлхийн хэмжээнд гэхэд л нийт цэвэр усны 1.9 хувь нь газар доор байдаг. Бусад нь ил байдаг гэсэн ийм судалгаа байдаг гээд би уншиж байсан юм. Тэгээд ер нь бол энэ дээр хийх юмнууд их байна. Энэ одоо орж ирсэн материалыг харахаар нийслэлийн хэмжээний юмыг л яриад байна гэж би ойлгосон. Тэгээд энэ хэмжээнд л юм асууя даа. Монгол Улсын хэмжээний юм ярих юм бол маш их хэмжээний юм яримаар байна. Энэ нийслэлийн цэвэр устай холбоотой юмыг ярихын тулд энэ Сэлбэ голын асуудлыг орхигдуулж ерөөсөө болохгүй. Энэ чинь цаг үедээ их сайхан том гол байсан юм гэсэн шүү дээ. Улам л багасаад байгаа. Зарим жил бүр ширгэчхэж байгаа. Тэгээд энэ эх үүсвэр нь энэ Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо гээд тэр 3 амнаас 3 ийм жижиг гол урсаж бий болгодог. Хойд талынх нь Санзайн ам, дунд Тахилтын ам, хамгийн зүүн талынх нь бол Ундраа зуслантай ам гээд. Тэгээд

бүх тэр бургасыг нь бүгдийг нь хядаад, байшин барьж байгаа юм. Үнэхээр харамсалтай. Үнэхээр харамсалтай бүр нүд халтирмаар байгаа шүү дээ. Тэгээд манай байгаль хамгаалдаг хүмүүс, нийслэл энэ тэр одоо яадаг юм мэдэхгүй. Сүхбаатар дүүргийн Засаг дарга бол байнга тэнд газар олгож байгаа. Одоо 4 га-гаар нь олгочихсон. Тэгээд хүмүүс худалдана гээд явж байгаа байхгүй юу. Тэгээд тэр нь бол дандаа бургас. Тэгээд ийм л байдалтай байгаа байхгүй юу. Тэгээд энийг яаж зохицуулах ёстой юм. Сая сайдын үгэнд бол Нийслэлийн Засаг даргад захирамж цуцлуулах талаар бичиг өгсөн, хариу алга л гэж байна. Энэ хууль энэ тэрээ санаачлаад, бид нар дэмжье. Ер нь энэ нийслэл газар олгохдоо ялангуяа усны эх үүсвэртэй газар газар олгохдоо байгаль орчин хамгаалах байгууллагуудтай зөвшилцөж олгодог, хэрвээ тэрийг зөрчиж олгосон тохиолдолд бол Байгаль орчны сайд бол тэрийг цуцалдаг эрхтэй болох ийм эрх зүйн орчин энэ тэрээ бүрдүүлбэл яасан юм. Үнэхээр харамсалтай нь байна шүү дээ. Одоо сая өгч байгаа энэ бүр яг эх үүсвэртэй газар бол миний ойлгосноор бол газар эзэмших 124778 одоо тийм нэгж талбай, өмчлөх 77300 тийм талбай өгчихсөн байна гэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь бол ерөөсөө л усны эх үүсвэр дээрээ л аваачаад л өгчхөж байгаа байхгүй юу. Тэгээд энийг одоо ер нь ямар боломжууд байна. Энэ Сэлбэ голынхоо урсцыг нэмэгдүүлэх талаар ямар боломж байна. Манай Байгаль орчны яам, нийслэл юу гэж бодож байгаа юм. Зүгээр л эрэг нь хамгаална барина, барилгажуулна, янз бүрийн юм хийнэ гээд нэг юм яваад байх шиг байгаа юм. Төсөл яваад байх шиг байгаа юм. Энэ урсцыг сайжруулах, эх үүсвэрийг нь хамгаалах, нэмэгдүүлэх тэр чиглэлээр ямар ажил хийгдэх вэ. Ийм асуулт байна.

Б.Энх-Амгалан: Хэн хариу хариулах вэ. Байгаль орчны сайд хариулъя. 3 номерын микрофон. Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Сэлбэ голын асуудал Монгол Улсын Засгийн газар дээр маш өндөр ач холбогдол өгч, Сэлбэ төслийг эхлүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн яамнаас бол тодорхой төсвийг 2023 онд албан ёсоор тавьж өгсөн байгаа. Сэлбэ төсөл бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бас ахлаад, бүх ажлууд бол явагдаад эхэлчихсэн явж байгаа. Зөвшөөрөлтэй холбоо бүхий асуудал байна. Би түрүүн ч хэлсэн, одоо ч дахин хэлэхэд нийслэл, дүүрэг, аймаг, сумдын Засаг дарга нарын олгосон газартай холбоо бүхий асуудал дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам зөвхөн цуцлах санал хүргүүлэхээс өөрөөр юу ч хийх боломжгүй ийм эрх зүйн орчинтой бид нар өнөөдөр байгаа. Тухайлах юм бол Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9 дээрээ газар эзэмших, ашиглах энгийн зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгохоор заагаад, мөн хуулийн 3.2 дугаар зүйлийн 1-д зааснаар энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, шийдвэр гаргах эрхийг бол хуульчлаад өгчихсөн. Газрын тухай хуулийн 40.1 дээр аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга дараах тохиолдол газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгон гээд ингээд бүрэн эрхэд нь хамааруулаад нөгөө талд нь заачихсан. Ингээд Газрын тухай хуулийн 20.2, 20.2.2, 20.2.6, 20.2.9 гэх мэтчилний ийм заалтууд. Усан парк дээр би жишээ хэлсэн. Сэлбэ голтой холбоо бүхий асуудал дээр тухайн байшин барилга баригдаж байгаа асуудал бол 2022 оны 9 дүгээр сард иргэн Жаргалсайханы Энхбатаас бол ирсэн. Энэ дээр бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас би сайдын хувьд ч гэсэн өөрөө РЦНК-ийн урд талын тухайн газар олголттой холбоо бүхий асуудлуудыг бол очиж хөндөж, Сэлбэ голтой холбоотой саяын хэлсэн ялангуяа бургас хядаж, байшин барьсантай холбоо бүхий асуудлыг мөн иргэн Энхбат хэлсний дагуу мэдээлсэн. Энэ бол бүр

өнгөрсөн 2022 оны хавар мэдээлсэн асуудал. Энэ дээр бол Сүхбаатар дүүргийн Засаг даргад тухайн газар олголтуудыг бол бүгдийг цуцлахыг шаардсан. Өнөөдрийг хүртэл газар олголт цуцлагдаагүй байгаа гэдэг мэдээлэлтэй байгаа. Захиргааны эрх зүйн онолоороо захиргаа өөрөө нэгдмэл байх ёстой. Захиргаа захиргаатайгаа маргах нь бол захиргааны хэргийн шүүхийн маргаан биш болчихдог. Тэгээд энэ утга агуулгаар нь харахаар захиргааны байгууллагыг захиргааны байгууллага өөрөө шүүхэд өгөөд байх ийм боломжгүй хэлбэр агуулагдчихаж байгаа юм. Тэгээд бид нар өнөөдөр хууль, эрх зүйн орчин дээрээ л тоглох ийм асуудал бол байна. Тэгээд өөрчлөлтүүд хууль, эрх зүйн орчин дээр тодорхой өөрчлөлтүүд оруулах боломжтой, яаралтай оруулж гэдэг энэ асуудлыг бас хөндөж байна. Тэгээд байгаль орчны багц хуулиуд дээр бид нар энэ асуудлуудыг бас давхар тусгахаар ажиллаж байгаа. Тэгэхгүй бол зөвхөн олгосон эрх бүхий этгээд нь цуцлах эрх бүхий этгээд болдог. Бусад байгууллагууд жишээлбэл захиргааны байгууллагуудын хувьд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал саналын хэмжээнээс хэтрэхгүй байдалтай л байгаа. Ойн тухай хууль, Усны тухай хууль ялангуяа үндэсний аюулгүй байдлын хүрээлэн буй орчны асуудал бол 3 авч эрхлэх асуудлын нэг асуудал байдаг. Тэгээд ямар сайндаа одоо бид нар Эрүүгийн хуулийн хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа хор хохиролтой холбоо бүхий асуудал дээр Улсын Ерөнхий прокурорт хандах хэмжээний л түвшинд явж байна. Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр саяын миний хэлсэн Зөвшөөрлийн тухай хууль, Газрын тухай хууль, холбогдох хууль, тогтоомжуудаар эрх зүйн орчинд зөвшөөрөл олгогч этгээд нь зөвшөөрлийг цуцлах байдлаар хуульчилсан учраас бид нар энэ дээр ямар ч арга хэмжээ авч чадахгүй байгаатай л холбоо бүхий асуудал болчихож байгаа юм.

Б.Энх-Амгалан: Баттөмөр гишүүн нэмж тодруулъя.

Б.Баттөмөр: Бат-Эрдэнэ сайд аа, энэ байгаль хамгаалах асуудал, ялангуяа энэ усны эх үүсвэрийг хамгаалах асуудал маш чухал асуудал. Тэгэхээр ямар эрх зүйн орчинд ямар бий болгох вэ. Энийгээ санаачлаад бас Их Хуралтай хамтарч ажиллаач. Энэ дээр бол Их Хурал тодорхой эрх зүйн орчныг бүрдүүлж өгье.

Хоёрдугаарт нь энэ ойн нөхөрлөлийн хууль гэж байдаг. Танай яаманд харьяалагдаж, танай яам бас хяналт тавьж ажилладаг байх. Тэгээд энэ бол хэрэгжихгүй байгаа. Маш их олон хүмүүс ойжуулъя гэдэг. Дүүргүүд нь зөвшөөрдөггүй, ойжуулъя гээд байхад зөвшөөрдөггүй. 1 хүн ярьж байсан. 1000 мод тарьчаад ороод ирсэн доод талд нь бургас хядаж байсан. Тэгээд ерөөсөө хаясан гэж. Тэгээд ийм ийм юм байна. Сэлбэ голын эхээ нэг явж үзээч. Тэр байшин, барилга бариагүй байгаа тэр газруудыг цуцлах талаар юу хийж болох вэ. Маш их хэмжээний газар олгогдсон. Ялангуяа тэр дунд талын ам, Тахилтын аман дотор бол 10 хэдэн га газар худалдана гээд л явж байгаа байхгүй юу. Энийг цуцалмаар байна.

Б.Энх-Амгалан: Санал хэлчихлээ. Байгаль орчны сайдаас 1 асуулт, Барилга, хот байгуулалтын дэд сайдаас 1 асуулт, Нийслэлээс 1 асуулт асууя. Энэ сүүлийн 10 жилд Монгол улсад 887 гол ширгэлээ, 2096 булаг шанд, 1166 нуур цөөрөм ширгэлээ. Хур тунадасны хэмжээ жилийн жилд ордог хэмжээ 10 хувиар буурлаа. Бэлчээрийн доройтол 65 хувьд хүрлээ. Малын тоо толгой 120 сая хонин толгойгоор үзэхэд боллоо. Бэлчээрийн даац 5-10 дахин хэтэрлээ гэж байгаа юм. Тэгээд энэ цөлжилт чинь маш эрчимтэй явагдаж байна. Тэрний 49 хувь нь хүний хүчин зүйлийн нөлөөнөөс болж байна. Тэгэхээр цаашид Монгол Улс байгаль орчны энэ доройтлынхоо асуудлыг, ялангуяа энэ ус гол, мөрөн ширгээж

байгаа энэ өвөл ингээд ундны усны аюулд өртөх магадлалтай болж байгаа энэ асуудлаа цаашидаа ер нь яг яах вэ. Энэ нөгөө томоохон уул нуруудынхаа усыг авч цөөрөм үүсгэдэг, хөв үүсгэдэг ийм юмаа хэзээ хийх юм бэ. Энэ голуудынхаа усыг татаж усан сан үүсгэдэг юмнуудаа хэзээ яаж хийх юм бэ. Монгол Улсын төрийн бодлого энэ дээр яаж явах юм бэ гэдэг талаас нь асуух гээд байгаа юм.

Барилга, хот байгуулалтын яамнаас асуух гээд байна л даа. Танай чинь нөгөө ариутгах татуургыг хариуцдаг шүү дээ. Энд бол хэд хэдэн ийм асуудлууд гарч ирээд болдоггүй.

Нэг дэх нь. Одоо сая бол гайгүй байгаа, ерөнхийдөө бол усны нөөц байж байгаа л гээд байдаг. Тэгтэл эрүүл ахуйн асуудал, нян судлалын шинжилгээнийхээ дүнгээр төв, био комбинат, Нисэх, Харгиа, Баянхангай, ХӨСҮТ, Баянголын цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарч байгаа бохир усны дээжид гэдэсний бүлгийн нян илэрсэн. Хүрээлэн буй орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлагад стандартын шаардлагад нийцэхгүй байгаа гээд ингээд гараад ирж байна. Ирүүлсэн та нарын юман дээрээс би харж байгаа шүү.

2 дахь нь Ус сувгийн удирдах газрын 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар өгсөн тайлан дээр 6166 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийж ажиллаж байна. Тэрний 473 аж ахуйн нэгж өндөр бохирдолтой ус нийлүүлж байна гэж байгаа юм. Энийг ингээд нийлүүлээд байгаад байх юм уу, энийгээ зогсоох юм уу. Тэгээд та бүхэн маань болохоор болж байгаа гээд юм яриад байдаг. Одоо яг энэ Био Комбинат дээр цаашаага тэр Туул голыг дагасан тэр хэсгүүд дээр чинь малчид ирээд үз. Энэ малын чинь элэг нов ногоон боллоо. Энд чинь ямар ч цэвэрлэгээгүй ийм ус явж байна гээд ингээд яриад байдаг. Энэ чинь хүний эрүүл мэндэд хортой. Энэ аюулгүй байдалд энэ ундны усны аюулгүй байдал гээд тийм чинь хэцүү болчихсон гэдэг

ийм дүн гараад байдаг. Өнөөдөр хүлээж авч байгаа бохир усны чинь 10 хувь нь стандартаас 5-140 дахин өндөр бохирдолтой ус орж ирж байна. Тэр дундаа төвлөрсөн системд холбогдоогүй бүсэд цооногт олон сар хуримтлагдсан зөөврийн ус маш их хэмжээг эзэлж байна гээд байгаа юм. Энэ ямар зөөврийн ус байдаг юм. Энийг цаашидаа яах юм. Ийм ийм асуудал дээр ариутгах татуургынхаа юмнуудыг хийгээдхээч. Тэгээд сая Төрхүү дарга бол бид нар бол арга хэмжээ авч байгаа болж байгаа гээд байдаг. Энэ харгиа чинь юу болсон бэ. Наадах чинь нөгөө бодис нь хэтэрчихсэн тэр нөгөө химийн бодистой юм нь их ороод, тэгээд төв цэвэрлэх байгууламжийн нөгөө биологийн идэвхтэй бодисуудыг нь устгаад хаячихдаг. Тэрнээсээ болоод цэвэрлэж чаддаггүй гээд л юм яриад байдаг. Тэр нь хэвээрээ байна уу эсвэл та нар янзалчихсан уу. Ийм асуудлыг асууя.

Дээр нь энэ манай нийслэлийнхэн юманд жоохон ач холбогдол өг л дөө та нар. Монгол Улсын нийт хүн амын 50 хувь Улаанбаатартаа сууж байгаа шүү дээ. Нийт газар нутгийнхаа 0.03 хувь дээр нийт хүн амынх нь 50 хувь сууж байгаа шүү дээ. Усны бохирдолтой, хөрсний бохирдолтой маш хүнд байдалтай байж байдаг. Энэ нийслэлийн Хот байгуулалтын хөгжлийн газар, нийслэлийн Байгаль орчны газар 2-ын чинь мэдээ зөрөөд байна шүү дээ. Та нар одоогийн байдлаар нийслэлийн ус хангамжийн 7 эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсэд хууль, журам зөрчиж 4487.9 га талбай бүхий 12574 нэгж талбарт иргэнд газар эзэмших, ашиглах ийм зөвшөөрөл олгосон гээд Байгаль орчны газар чинь мэдээлэл ирүүлсэн. Гэтэл Хот байгуулалт хөгжлийн газар нь болохоор одоогийн байдлаар 8 байршилд ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуй хориглолтын бүсэд 4053 аж ахуйн нэгжид 2389.9 га газар олголт хийсэн гээд ийм 2 том зөрөөтэй тоо яваад байдаг. Алийг нь барих юм бэ. Тэгээд энэ ундны усны эх үүсвэрийг нь

хамгийн хориглолтын бүсэд барьчихсан аж ахуйн нэгжүүд энэ юмнуудаа тэгээд хөөж явуулахгүй юм уу. Арга хэмжээ авахгүй юм уу. Ийм тогтоол гарсан, тэгсэн гээд ингээд суугаад байдаг энийг чинь ингэхгүй бол цаашидаа энэ Улаанбаатар чинь ундны усгүй болох юм биш үү. Эрүүл ахуйнх нь нөхцөл байдал алдагдаад, хүн ам чинь ундны усаар гачигдах юм биш үү гэдэг ийм 3 асуулт байгаа юм. Эхлээд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ сайд хариулъя. 2 номерын микрофон. Дараа нь Золбоо сайд хариулъя. Тэгээд дараа нь нийслэлийнхэн хариулъя. Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгье. 3 номерын микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Энх-Амгалан даргын асуултад хариулъя. Сүүлийн 80 жилийн хугацаанд Монгол Улсын агаарын хэм 2-2.25 хэмээр нэмэгдсэн. Монгол Улс бол уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нэрвэгдэж байгаа 10 орны 1. Хур тунадасны хэмжээ жилийн 7.3 хувиар багассан. Нийт бэлчээр 75 хувь боловч 57 хувь нь доройтсон. Цэвдэг сүүлийн 40 жилийн хугацаанд 30 хувь алдсан. Өнөөдрийн энэ уур амьсгалын өөрчлөлт хэрвээ энэ янзаараа явагдах юм бол 2100 он гэхэд Монгол Улсын агаарын температур 4-4.5 хэмээр нэмэгдэхээр байгаа. Дэлхийн агаарын хэм 2030 он гэхэд 1.5 хэмээр нэмэгдэх хэмжээнд явж байгаа. Монгол Улс бол 2100 он гэхэд 4-4.5 хэмээр нэмэгдэх ийм асуудал. Нийт газар нутгийн 76.9 хувь нь цөлжсөн, 90 хувиас дээш цөлжилттэй аймгуудын тоо нэмэгдсээр байгаа. 51 хувь нь байгаль орчны, 49 хувь нь хүний хүчин зүйлээс шалтгаантай гэдэг ийм асуудал бол байгаа. Ундны усны хомсдолд орох асуудал Монгол Улсад байна уу гэвэл байна. 98 хувь нь гадаргын, 2 хувь нь гүний, газрын доорх, 98 хувийнх нь 60 хувь нь гадагшаа урсацтай. Таны хэлсэнчлэн бид нар энэ 98хувийн 60 хувийг бид нар гадагшаа урсацтай гол мөрнүүдийг хэрхэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр илүү их километр

туулуулж, хөрсний болон бусад ач холбогдолтой талаар нь ашиглах вэ гэдэг ийм тооцоо судалгаа хийгээд, үүний үндсэн дээр ч гэсэн “Хөх морь” төсөл явагдаж байгаа.

Хөв цөөрөм байгуулах асуудлууд байна. Голын уснуудыг татахтай холбоо бүхий асуудлууд байна. Нэг талдаа хөрөнгө оруулалттай холбоо бүхий асуудлууд байгаа боловч нөгөө талдаа бид нар хамгааллын асуудлууд их хэмжээгээр яригдаж байгаа ийм цаг хугацаанд бид нар амьдарч байна. Ялангуяа энэ усны хомсдолтой холбоо бүхий асуудал дээр бид нар зөвхөн усны ундарга болон хөв цөөрөм байгуулахтай холбоо бүхий тооцоо судалгааг хийж үзэхэд Улаанбаатар хотыг тойроод тухайлах юм бол 18 хөв цөөрөм байгуулах ийм боломж байгаа. Энэ 18 хөв цөөрмийн тооцоо судалгаа, ТЭЗҮ-г эхний байдлаар хийхэд 1 сая ам доллар бид нарт шаардлагатай байгаа. Энийг бид нар Монгол Улсын төрийн төсөв дээр тавих боломжгүй учраас Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкт бид нар энэ асуудлуудыг бас мөн яриад явж байх жишээтэй байна.

Усан сан байгуулахтай холбоо бүхий асуудлууд нөгөө талдаа хөндөгдөж байна. Сэлбэ голыг түшиглэсэн усан сан байгуулах асуудлуудыг бид нар хөндөж байгаа. Нэг талаасаа тухайн орон нутгийн буюу тухайн газар орон нутагт оршин сууж байгаа иргэдийн эсэргүүцэл тэмцлүүд бас нөгөө талдаа байна. Ялангуяа энэ гол уснуудыг татах олон километр туулах, туулуулах энэ ажлууд дээр бол бас орон нутагтаа ойлголцох ийм асуудлууд бас нөгөө талдаа байгаа юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай бид нар ялангуяа энэ бэлчээртэй холбоо бүхий асуудлуудыг хөндөж байгаа. Энийг яагаад бид нар хөндөж байгаа вэ гэхээр цаашид бид нар цэвдгээ авч үлдэхтэй холбоо бүхий асуудлыг хөндөхгүйгээр гадаргын дээрх

болон газрын гүний усыг, хөрсийг, модыг, бэлчээрийг бид нар авч үлдэх тухай ойлголт байхгүй. Та сая хэллээ. Нийт малын даац маань хэтэрчихсэн. Олон улсын байгууллагаас хийсэн судалгаа шинжилгээгээр Монгол Улсын яг өнөөдрийн байгаа бэлчээрийн даац маань 25 сая. 2023 оны статистик тооцоо судалгаагаар 71 саяд хүрчихсэн байгаа. Энэ янзаараа бид нар үргэлжлээд явах юм бол 2030 он гэхэд бид нар малтай байх уу, үгүй юу гэдэг асуудал хөндөж байгаа юм. Олон улсын байгууллагуудын түвшинд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг бид нар 2030 он гэхэд 30 хувьд хүргэх ёстой байна. Одоо бол 21 хувь буюу 32.8 сая га талбай хамрагдсан байгаа.

Б.Энх-Амгалан: Нэмж хариулах уу та. Бат-Эрдэнэ сайдын микрофоныг нэмж өгье. 3 номер гүйцээгээд хариулчихъя.

Б.Бат-Эрдэнэ: Орхон-Онги төслийн хувьд бол бид нар Онги голоос Улаан нуур хүртэл бол 236 километр ус дамжуулах далд шугам хоолойг жишээлбэл барих шаардлагатай байгаа. Энэ дээр бол Оюутолгой компани болон Эрдэнэс тавантолгой компани тодорхой санхүүжилтийг гаргаад бид нар хийхэд бэлэн байна гэдгээ мэдэгдэж байгаа. Хамгийн гол нь бид нар 6.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг яаралтай шийдвэрлэх ийм асуудал байна. Дээрээс нь би түрүүн хамгааллын асуудлууд ярьсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2020 оны А/59 тоот тушаал усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлалын дагуу нөхөн төлбөрийг тооцож байгаа. 12.2 га газар дээр бид нар нөхөн төлбөр тооцуулахаар 2022 онд шийдвэр гарсан. Энэ бол 795 сая төгрөгийн нөхөн төлбөртэй холбоо бүхий асуудал байгаа. Усны нөөцийн бохирдолтой учирсан хэсэг дээр бид нар 5 га орчим дээр судалгаа хийсэн. Энэ бол 5 га дээр 773 сая төгрөгийн хохирол тооцогдож байгаа юм. Ус бохирдуулсны төлбөрийн тухай

хуультай холбоо бүхий асуудал байна. Энэ дээр бол Ус сувгийн удирдах газар 2021 оны хаягдал усны дүгнэлтээр бол 2.3 тэрбум төгрөгийг тооцохоор байгаа. Ус бохирдуулсны нөхөн төлбөрийн 8 тэрбум төгрөг жишээлбэл өнөөдрийн байдлаар төлөгдөөгүй байна. Нийслэлийн Засаг даргаас бол Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад 2 сарын 24-ний өдөр бичиг ирсэн. Энэ нөхөн төлбөрийг төлөхтэй холбоо бүхий асуудал дээр бол ус бохирдуулсны төлбөр төлөгч байх хууль эрх зүйн үндэслэлгүй гэдэг ийм зүйлийг бол манайд ирүүлж байгаа юм. Тэгээд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу усны газар болон Ус сувгийн удирдах газар, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хооронд үүсээд байгаа ус бохирдуулсны төлбөрийн асуудлыг судлан шийдвэрлэх шаардлагатай гээд. Энэ төлбөрийг бол бид нар нэхэмжилж байгаа. Энэ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль байна. Усны тухай хууль байна. Мөн энэ эко системтэй холбоо бүхий асуудлууд байна. Энэ бол төв цэвэрлэх байгууламжтай холбоо бүхий асуудал. Энийг бид нар шийдвэрлэхгүйгээр нөгөө талдаа бид нар хамгааллын усан сан, хөв цөөрөм байгуулах ийм ажлуудыг 1 талдаа хийгээд байгаа боловч нөгөө талдаа бид нар хамгааллыг хийхгүйгээр өнөөдрийн Туул голын 5 аймаг 37 сум ялангуяа энэ Төв аймгийн энэ цэвэрлэх байгууламжаас цаашаа ус урсаж байгаа энэ бохирдолтой холбоо бүхий асуудал экологийн тэнцвэрийг алдагдуулж байгаа энэ байдлыг бол бид нар яаралтай таслан зогсоохоос өөр аргагүй байдалд л байна.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Бат-Эрдэнэ сайдад. Одоо Золбоо сайд хариулъя 2 номерын микрофон. Золбоо сайд нэлээн нарийн юмнууд үзээрэй. Та энэ цэвэрлэх байгууламжуудтай холбоотой энэ нян судлалын шинжилгээгээр бол энэ полиовирус, полио бус энтеро вирус гээд гэдэсний бүлгийн

савханцар гээд ингээд олон олон ийм юмнууд илэрсэн байна шүү. Энэ Эрүүл мэндийн яамны мэдээн дээр байна. Тийм учраас энэ ариутгах татуургах асуудал дээр нэлээн юм харахгүй бол болохгүй юм байна. Яриарай.

Э.Золбоо: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Цэвэрлэх байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал бол маш хүнд нөхцөл байдалд байгаад энэ бол 2 үндсэн шалтгаантай гэж болбол хэлж болно.

Нэгдүгээрт цэвэрлэх байгууламж өнөөдөр хоногт 150,000 метр куб хүлээн авах хүчин чадалтай бол 180-200 мянган метр куб бохир усыг хүлээн авч, цэвэрлэж байгаа. Ингэхээр үйл ажиллагаа нь энэ хэрээрээ доголдож байгаа гэсэн үг.

Хоёрдугаарт Төв цэвэрлэх байгууламж руу ирж байгаа бохир уснууд бол стандартын шаардлага хангаагүй байгаа. Хүний эрүүл мэнд болон байгаль орчинд аюултай ийм нөхцөл байдалтай бохир ус ирж байгаа. Яагаад гэвэл Төв цэвэрлэх байгууламжийн үндсэн зорилго бол ахуйн хэрэглээний бохир усыг хүлээн авах ийм зорилттой. Гэтэл өнөөдөр ямар нөхцөл байдал байгаа вэ гэхээр ахуйн хэрэглээний бохир усыг хүлээж авахаас гадна энэ үйлдвэрүүдийн бохир усыг урьдчилан цэвэрлээгүй байдлаар хүлээж авч байгаа. Энэ нь бол холбогдох хуулиудыг зөрчиж байгаа, холбогдох стандартуудын зөрчилтэй гэсэн үг. Жишээлэх юм бол хот, суурин газрын ус хангамж ариутгах татуургын хуультай зөрчилтэй байна гэсэн үг. Тэгээд энэ нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр бол тодорхой ажлууд Засгийн газар дээр хийгдээд явж байгаа. Би түрүүн хэлсэн.

Нэгдүгээрт хоногийн 250 мянган метр куб хүчин чадалтай бохир усыг цэвэрлэх хүчин чадалтай шинэ төв цэвэрлэх байгууламж байгуулагдаж байгаа. Энэ бол стандартын шаардлага хангасан, хамгийн сүүлийн үеийн

технологи бүхий цэвэрлэх байгууламж. Тэгээд ийшээ ирж байгаа усыг бид бүхэн ямар нэгэн бохирдолгүй стандартын шаардлага хангасан, хуулийн хэрэгжилтийг хангасан ийм бохир усыг хүлээж авах нь зүйтэй юм байна гэдэг үүднээс Засгийн газар дээр үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байгаа. Энэ бол 70 үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулна. Энэ арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Тэгээд энэ ажлын хэсэг бол энэ хэрэгжилтийг хангаад явж байгаа. Шинэ цэвэрлэх байгууламж бол 2024 оны 8 сард ашиглалтад орно гэж байгаа. Тэгээд энэ цэвэрлэх байгууламж ашиглалтад ороход л бид нар энэ үйлдвэрүүдийн бохир усыг стандартын шаардлага хангуулах руу нийцүүлчихсэн байх шаардлагатай. Тэгээд манай ажлын хэсэг бол энэ 60 арга хэмжээг бол холбогдох хууль эрх зүйн орчнуудыг сайжруулах холбогдох стандартуудыг шинээр боловсруулж батлуулах, үйлдвэрүүдтэй тулж ажиллах мэдээлэл өгөх энэ үйлдвэрүүдийг үйлдвэр өөр дээр нь бие даасан урьдчилсан цэвэрлэх байгууламж байгуулах эд нар гээд ажлыг зохион байгуулж байгаа.

Тэгээд өнөөдөр яг Улаанбаатар хотын хэмжээнд яг цэвэрлэх байгууламж руу энэ аюулгүй ус очиход бол бидний тооцооллоор бол 200 гаруй үйлдвэр байгаа. Тэгээд энэ 200 гаруй том үйлдвэрүүдийг дор бүрнээ урьдчилсан цэвэрлэх байгууламж бариад энэ усаа цэвэрлээд цэвэрлэх байгууламж руу очих юм бол стандартын шаардлага хангагдана гэж үзэж байгаа. Тэгээд энэ 200 үйлдвэрүүдтэйгээ бид бүхэн ажлын хэсэг дээр бол байнга ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар бол 25 орчим үйлдвэр ялангуяа арьс шир боловсруулах үйлдвэр, ноос ноолуурын үйлдвэрүүд урьдчилсан байдлаар цэвэрлэх байгууламжаа барьчихсан явж байгаа. Хүнсний үйлдвэрүүд, цаасны үйлдвэрүүд гэх мэт үйлдвэрүүдтэй бол бид бүхэн ажиллаж байгаа. Ямар ч байсан энэ

үйлдвэрүүддээ юу гэж ойлгуулж байгаа вэ гэхээр 2024 оны 8 сард шинэ цэвэрлэх байгууламж баригдана. Энэ үед бол та бүхэн заавал урьдчилсан цэвэрлэх байгууламж байгуулж усаа цэвэрлэж стандартын шаардлага хангуулахгүй бол бид бүхэн цэвэрлэх байгууламж руу бохир усыг нийлүүлэх арга хэмжээг зогсооно гэдэг арга хэмжээ авч байгаа. Энэ нь бол 1 талдаа бол хуулийн хэрэгжилтийг хангаж байгаа стандартыг хангаж байгаа.

Хоёрдугаарт. Бид нар түрүүн хэлж байгаа мянганы сорилтын сантай хамтраад 2 маш том төсөл хэрэгжүүлэх байгаа. Энэ 2 том төсөл хэрэгжүүлэх 2 талаасаа үүрэг хүлээсэн нэг үүрэг бол шинэ цэвэрлэх байгууламж руу стандартын шаардлага хангах усыг бид нар нийлүүлнэ гэдэг үүрэг би хүлээсэн. Энийгээ бол хэрэгжүүлээд явна. Тэгээд энэ Мянганы сорилтын сангийн нэмж мэдээлэл өгөхөд төсөл хэрэгжээд эхлэх юм бол нийтдээ Улаанбаатар хотын.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Золбоо сайдын микрофоныг нэмээд өгье. Гүйцээгээд хариулчихъя. 2 номерын микрофон.

Э.Золбоо: Өнөөдөр нийт Улаанбаатар хотын усны хэрэглээний 25 хувийг бол 3, 4 дүгээр цахилгаан станц дээр зүгээр ингээд цэвэр ус хэрэглэж байгаа. Тэгээд энэ Мянганы сорилтын сангийн төсөл хэрэгжихээр бид нар цэвэрлэх байгууламж руу ирж байгаа бохир усыг дахин 3, 4 дүгээр цахилгаан станц руу ашиглах шаардлагатай ийм төсөл байгаа. Тэгээд энэ шаардлагыг биелүүлэхийн тулд шинэ цэвэрлэх байгууламж руу бид нар стандартын шаардлага хангасан бохир усыг аваачна. Ингэхийн тулд энэ үйлдвэрүүдтэй тулж ажиллаж байгаа гэдэг мэдээлэл өгье. Тэгээд тэр нөгөө шинжилгээний хариу энэ тэртэй холбоотой мэдээллийг өгөх байх.

Б.Энх-Амгалан: 2 номер дээр суучих. Эрүүл мэндийн яам, нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд хариулаарай. 2 номерын микрофоныг өгье.

Б.Баясгалан: Эрүүл мэндийн яам Салбарын хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын Ахлах байцаагч Баясгалан гэж хүн байна. Энэ нөгөө вирус тодорхойлсон шинжилгээний дүн асуугаад байх шиг байна. Бид нар нөгөө корона гарч эхэлсэнтэй холбоотойгоор ерөнхийдөө бохир усанд нөгөө коронагийн энэ sars cov 2 вирус бол нэлээдгүй илэрч байгаа гэсэн олон улсын судалгаа шинжилгээнээс үзээд бид нар бас энэ дээрээ хяналтаа тухайн үед төвлөрүүлж ажиллаж байсан. Эхний үед бол бид нар нөгөө вирус тодорхойлж чадахгүй байсан учраас нян судлалынхаа шинжилгээ дээр үндэслээд тэгээд бас Ус сувагтайгаа ярьж байгаад бүгдээрээ энэ халдваргүйжүүлэлт дээрээ, орж ирж байгаа бохир ус дээрээ халдваргүйжүүлэлт хийе. Төв цэвэрлэх дээр гэхэд 3, 4 цэг дээр халдваргүйжүүлэлт хийгээд энэ шинжилгээнийхээ дүнг үзье гэдэг ийм байдалтай байсан. Ингээд 4 цэг дээр хлороор халдваргүйжүүлэлт хийгээд дараа нь бол шинжилгээ авсан. Энэ дээр бол нянгийн бохирдол бол маш их буурч ирж байсан. Тэгээд нянгийн бохирдол нэлээн буурч байна гэдэг энэ асуудлыг яриад дараа нь Ус сувгийн удирдах газрын Төрхүү дарга бас маш их зардал гарч байна. Энэ хлоржуулалтыг ингэж олон цэг дээр хийснээс бид нар зардлаа дийлэхээ байлаа гээд 2022 онд энэ халдваргүйжүүлэлтээ хийхгүй болсон. Энэ үед бол бид нар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийнхөө вирус судлалын лабораторитой ярилцаж байгаад дээж авч шинжлүүлсэн. Энэ дээж дээр яг тэр нөгөө халдваргүйжүүлэлт зөвхөн гарч байгаа цэг дээр халдваргүйжүүлэлт хийж байгаа нөхцөл дээр авсан дээжид бол sars cov 2 маань нэлээн олон энэ нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа энэ цэвэрлэх

байгууламжууд дээр бүгдэд нь гарч байсан. sars cov 2 энэ чинь тэгээд Туул голын усанд орчихно. Мөн Туул голын усан дээр бол энэ вирусийн хэмжээ гарч байсан. Тэгэхээр бид нар энэ асуудлыг тухайн үед яриад ер нь халдваргүйжүүлэлт хийх нь зөв байна. Халдваргүйжүүлэлтийг хийхдээ 3 цэг дээр хийе гэдэг энэ асуудал тухайн үед бол яригдаж байсан. Тэгэхдээ халдваргүйжүүлэлт хийсний бас 1 эсрэг тал нь химийн хэрэгцээт хүчил төрөгчийн агууламж өндөрсөөд ирж байсан. Бүр 2000 гараад, энэ чинь 30 микрограмм литр байх ёстой юм чинь бараг 2 мянга хэдэн зуугаараа гарч байсан нэг ийм сөрөг үр дагаврууд бол гарч байсан. Тэр шинжилгээний дүнг бол энд ярьж байна.

Мөн энтровирус тодорхойлох шинжилгээг Туул голын ус, цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усан дээр бол хийгдэж байсан. Нийт бол энэ дээр аймаг нийслэлийн хавсарсан 27 цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усны дээжид бол шинжилгээ хийснээс 12 дээжид энэ энтровирус гэдэг вирус бол илэрч байсан. Тэгэхээр энэ нян судлалын шинжилгээгээр нянгийн бохирдол өндөр гараад, эмгэг түвшний илрээд, энэ вирус илрээд байна гэдэг чинь өөрөөр хэлбэл тэр цааш нь байгальд нийлүүлж байгаа тэр голын эх үүсвэр ч юм уу, хөрс ч юм уу энэ маань энэ вирусээрээ бохирдоод, эргээд хүний эрүүл мэдэлд нөлөөлөх ийм сөрөг үр дагавартай юм гэдгийг болбол хэлэх байна.

Тэр ундны усан дээр би бас хэдэн юм нэмээд хэлчихье гэж бодож байна. Манайх бол ундны усны хяналт шинжилгээг бол яг эрүүл ахуйн хяналт шинжилгээг бол жил бүр хэрэгжүүлдэг байж байгаа. Жилд дунджаар 1600 сорьцод дээж хийдэг байж байгаа. Энэ дээр бол түрүүн Сүнчин дарга бас ярьсан. Одоо би гол анхаарах асуудлуудыг нь энд хэлчихье гэж бодож байна. Ундны усны шинжилгээгээр бол

хатуулгийн агууламж бол 71 сум, магни агууламж бол 80 сум, төмрийн агууламж бол 32 сумд бол стандартын шаардлага хангахгүй гарч байна. Дээрээс нь хүнцлийн агууламж. Химийн хортой бодис хавдар үүсгэдэг гэж байгаа. Хүнцлийн агууламж бол говийн аймгуудын 17 сум байж байна. Ураны агууламж бол 42 сум, хар тугалганы агууламж бол 22 сумын усанд бол стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их гарч байгаа.

Б.Энх-Амгалан: Микروفон нэмээд өгье. Хариултаа дуусгачихъя. 2 номер.

Б.Баясгалан: Усанд бол усыг цэвэршүүлэх, цэвэрлэх төхөөрөмжийг яаралтай тавих ёстой байх. Хамгаалалтын бүсийн асуудал эрүүл ахуйн хориглолтын болон хязгаарлалтын хамгаалалтын бүсийн асуудлууд нэлээн яригдаж байна. Бид нарын хийсэн шинжилгээгээр бол нийслэлийн төвлөрсөн ус хангамжийн Гачуурт А, Б эх үүсвэр В эх үүсвэр байж байгаа. Дээрээс нь аймаг, Нийслэлийн 466 ундны усны эх үүсвэрт бол хамгаалалтын бүсийн дэглэм зөрчигдөж байгаа. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэм зөрчигдөж байгаа. Энэ нь ямар хор нөлөөтэй байна вэ гэдэг дээр бид нар бас анализ хийж үзсэн. Тэгэхэд 2013 онд тодорхойлсон бохирдлын химийн үзүүлэлтүүд байж байгаа. Аммиак, нитрат, нитритийн агууламж. Энэ нь 2022 онд тодорхойлсон дүнтэй харьцуулаад үзэх юм бол даруй энэ 4.0 хэд дахин бол энэ үзүүлэлтийн хэмжээ бол нэмэгдчихсэн байж байгаа. Тэгэхээр энэ хамгаалалтын бүсийн дэглэмийг тогтоохгүй энэ дэглэм алдагдаад ингээд явах юм бол ерөнхийдөө ундны ус маань бохирдож, газрын доорх усны эх үүсвэр маань бохирдох энэ нөхцөл дагуулж байна. Энэ бол маш аюултай үр дүн. Яах вэ цэвэрлээд хэрэглэх л байх тэгэхдээ маш их хөрөнгө гараад ингээд явах ийм асуудал гарч байгаа учраас энэ хамгаалалтын бүсийн асуудал дээрээ

маш их анхаарал хандуулъя гэж бодож байна.

Дараагийн нэг асуудал бол Улаанбаатар хотод төмрийн агууламж бас асуудалтай байгаа. Энэ нь болохоор нөгөө шугам хоолойн бохирдолтой холбоотойгоор жишээлбэл ундны усны эх үүсвэр дээр төмрийн агууламж бол маш бага хэмжээтэй байдаг. Гэтэл хэрэглэгч дээр нөгөө төмрийн агууламж маань 4-5 дахин нэмэгдээд ирдэг. Яах вэ өнөөдрийн түвшинд стандарт хэмжээнд байгаа ч гэсэн энэ маань бас ийм аюул дагуулах хэмжээнд байна аа гэдгийг бас хэлмээр байна.

Дараагийн нэг асуудал бол 6 аймагт ундны усыг халдваргүйжүүлэхгүйгээр нийтэд бол тарааж байгаа. Энэ асуудал бол бас хүндрэлтэй байна. Аймгуудыг нь хэлэх юм бол энэ Говьсүмбэр, Дундговь, Ховд, Хэнтий, Өвөрхангай, Завхан, Архангай аймгууд байж байгаа. Энэ дээр бас анхаарал тавихгүй бол бас нөгөө нянгийн бохирдол маань нэмэгдэх вий гэдэг асуудал байна.

Дараагийн нэг хамгийн их анхаарал татаж байгаа асуудал бол Зайсангийн 11 дүгээр хороолол байгаа. Энэ дээр бараг 20 хэдэн хотхон байгаа. Том том хотхонууд байгаа. Эд нар бүгдээрээ өөрсдийн гаргасан 62 гүний худаас бол ундаалж байгаа. Энэ 62 худаг дээр бол ямар ч эрүүл ахуй хамгаалалтын бүс байхгүй. Ямар ч дотоодын хяналт шинжилгээ байхгүй ийм усыг болбол хэрэглээд явж байгаа. Та бүхэн мэдэж байгаа байх нөгөө Асем вилла хотхоны хордлого байж байгаа. 400 гаруй хүн өвдсөн. Энэ бол бас ийм байдалтай үүссэн. Одоо ч бас энэ хотхонуудаас гэдэсний халдварт өвчнөөр өвдөх ийм байдал илрэх, усны хордлогот халдварт өртөх энэ байдал бол үүсэхэд нөхцөл бол бүрдчихсэн байж байгаа. Ийм нэг хүндрэлтэй асуудал байна гэдгийг хэлмээр байна.

Тэгэхээр энэ хүндрэлтэй асуудлуудаа шийдээд явбал бас болох байх.

Дараагийн 1 асуудал бол Туул голын асуудал байж байгаа. Бид нар бол Туул голд бас манай эрүүл ахуйн хяналтыг Туул голын усанд 9 цэг дээр хийж байгаа. Тэгэхээр нөгөө төв цэвэрлэх байгууламжийн маань цэвэрлэсэн бохир усны цутгагдахаас доошоо бол бохирдол маш их, их бохирдолтой ангилалд ороод явж байгаа. Ялангуяа тэр Туул тосгоны ард бол өвлийн үед нөгөө Туул голын ус маань нөгөө төв цэвэрлэхээс орж ирж байгаа усныхаа даацыг даах тийм чадваргүй болоод яг тэр Туул тосгоны ард тэр айлуудын хажууд хүртэл ийм халиа үүсчихсэн байдаг. Одоо ч очиход бараг үүсчихсэн байгаа байх. Тэгээд тэр халиа үүсээд яг тэр үнэр, танар гарсан ийм байдалтай байдаг. Тэгэхээр яг тэр Туул тосгоны иргэдийн хувьд яг эрүүл мэндэд бол нөлөөлөх ийм хүчин зүйл бол үүсчихсэн ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм.

Б.Энх-Амгалан: Эхлээд Тулга дарга хариулъя. Дараа нь Төрхүү дарга хариулъя. Тулга дарга та цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бүсэд олгогдсон 723 нэгж талбар 1137.7 га газар олголт, тэр дүүргийн Засаг даргын захирамжаар олгогдсон 141.2 га газар энийгээ яах юм бэ. Цаашид Нийслэлийн ус хангамжийн 7 эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсэд хууль журам зөрчиж олгогдсон 4487.9 га талбай бүхий 12574 нэгж талбар газраа яах юм бэ. Энэ талаар маш тодорхой хариулаадах. Наадах чинь бохирдуулагч нь шүү дээ. Бохирдуулагчийг нь бид нар цэгцлэхгүйгээр ерөөсөө юм явахгүй. Тэрний дараа бол Төрхүү дарга тэр нөгөө стандартын шаардлагад нийцэхгүй байгаа 400 хэдэн аж ахуйн нэгжээ яах юм бэ. Өндөр бохирдолтой усаа ингэсэн. Одоо ингээд Барилга, хот байгуулалтын сайдын хэлснээр бол тэр 250 мянган метр куб ус цэвэрлэдэг шинэ цэвэрлэх

байгууламж орох юм байна. Энэ рүү бол үйлдвэрлэлийн бохир усыг нийлүүлэхгүй юм байна. Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээ дэс дараатай авах юм. Энийг хариулаадахъя. Тулга дарга. 2 номерын микрофон.

Ц.Тулга: Нийслэлийн хэмжээнд бол нийтдээ 448 мянган нэгж талбар байгаа. Үүнээс ундны усны эх эрүүл ахуйн хөнгөн хорогдлын бүсэд 4654 нэгж талбар, 792 үл хөдлөх хөрөнгө, үүнээсээ 590 хашаатай ийм байдалтай байна. Усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд болохоор 5994 нэгж талбар байна гэсэн хот байгуулалтын мэдээллийн сангийн бүртгэл байгаа. Энэ мэдээллийг бол Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс бол нэгтгэж гаргасан нийслэлийн хэмжээнд гаргасан тоо байгаа. Ерөнхий төлөвлөгөөнд бол Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний ажил бол боловсруулагдаад явж байгаа. Монгол Улсын Засгийн газраар хэлэлцүүлэхэд бэлэн болсон. Энэ дээр бол яг энэ усны хориглолт хамгаалалтын бүсэд байгаа нэгж талбаруудыг нүүлгэн шилжүүлэх, энэ дээрээ бол шинэ суурьшлын бүсийг төлөвлөх, газар зохион байгуулалтын төлөвлөлт хийх, газар шинэчлэн зохион байгуулах энэ төлөвлөлтийн хүрээнд бол эко шийдлээр одоо байгаа барилга байгууламжуудыг төлж шийдэхээр ингэж шийдлийг боловсруулсан байгаа. Түүрүүн бас яригдсан байгаа нийслэлийн хэмжээнд байгаа булаг шандын тоо бол бас 229 булаг шанд байна. 19 рашаан байна гээд одоогийн байдлаар тооллого хийсэн. Энэнээс 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр тусгахдаа 18 булаг шандыг, 2 рашааныг нэмэлтээр бол тусгай хамгаалалтад авъя. Мөн экологийн коридоруудыг 3 газарт шинээр байгуулъя. Ингэхдээ бол нийтдээ 40.9 га талбайг бол энэ улсын тусгай хэрэгцээнд авъя гэсэн ийм шийдлүүдийг Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө дээр бол тусгаад ажиллаж байгаа.

Б.Энх-Амгалан: Төрхүү дарга хариулъя. 2 номерын микрофон дээр хариулъя.

Ц.Төрхүү: Би одоо бас жоохон цэгцтэй ярья гэж бодоод байна. Зүгээр яах вэ түрүүн асуусан асуултуудад. Нөгөө Харгиа цэвэрлэх байгууламжийг эхлээд Энх-Амгалан дарга асуусан. Түрүүн яриандаа оруулж. Харгиа цэвэрлэх байгууламж бол яг өнөөдрийн нөхцөл байдал нь бол их хүнд байгаа. Яагаад хүнд байгаа вэ гэхээр 2014 онд Монгол Улсын Их Хурлын тогтоол гаргаад Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлнэ гэхчхэн байдаг. Тэгээд одоо хүртэл нүүлгэн шилжүүлэгдэж чадаагүй байгаа. Нүүлгэн шилжүүлэхгүй байгаа. Тэгээд бид бүхэн тэр дээр бас хөрөнгө гаргаад, засвар үйлчилгээ болон техникийн үйлчилгээ болон юу хийх гэхээр ерөөсөө өөрчлөлт хийж болдоггүй болчихсон ийм нэг гацаатай байгаад байгаа юм. Харгиа цэвэрлэх байгууламжийн талд. Харин Харгиа цэвэрлэх байгууламжийг тойрч байгаа 28 аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2018 оны 73 дугаар тогтоолын хүрээнд Засгийн газрын 73 дугаар тогтоолын хүрээнд бид бүхэн өөрсдөө цэвэрлэх байгууламжтай болох гэдэг юун дээр анхаарал тавьж ажилласан. Барилга, хот байгуулалтын яам болон Улаанбаатар хотын захирагчаас тийм чиглэл өгч бид бүхэн бол тэр дээр тэгж ажилласан байж байгаа юм. Тэгээд өнөөдрийн байдлаар бол 20 гаруй аж ахуйн нэгж байгууллага бол урьдчилан цэвэрлэх байгууламжтай болчихсон байж байгаа юм. Мөн тэр цэвэрлэх байгууламжтай болсон ч гэсэн бохирдлын хэмжээ ерөөсөө буурахгүй байгаад байгаа юм. 1964 онд баригдсан Төв цэвэрлэх байгууламж бол Улаанбаатар хотын хүн амд нь судалгаагаар үзэхээр 500 мянган хүнд ашиглагдах ёстой ахуйн цэвэрлэх байгууламж байсан юм байна лээ. 1964 онд. Тэрнээс хойш өнөөдөр одоо 59 дэх жилд бараг л 60 дахь жил рүүгээ орчихсон явж байгаа бид бүхэн. Тэгээд

өнөөдөр хүн ам маань 1 сая 600 мянга орчим, орж гарч байгаатай нийлээд 2 сая орчим ийм хүн амтай болчихсон байж байгаа. Цэвэрлэх байгууламжийн өнөөдрийн нөхцөл байдал үнэхээр туйлын хүнд байгаа. Түрүүн Золбоо сайд ярьж байх шиг байна. Үнэхээр аваарын байдалтай бид бүхэн сүүлийн хэдэн жил ажиллаж байгаа. Яг аваарын байдалтай. Хоногт ирж байгаа усны хэмжээ бол 150- 170 мянган метр куб усыг аваад цэвэрлээд 80 гаруй хувьтай гаргаж байгаа. Өнөөдөр бол хоногт ирж байгаа ус бол 200 дөхөж орж ирж байна. Тэгэхээр нөгөө ачаалал маань бид бүгдэд маш их болчихсон. 24 цагийн ачаалалтай ажиллаж байна. Тэнд ажиллаж байгаа ажилчин, албан хаагчдыг хүртэл тогтооход хүнд бэрх байгаад байгаа юм. Байнгын тийм аваарын байдалтай ажиллаж байхаар хэн ч гэсэн тэнд ажиллаад байхыг хүсэх вэ дээ. Яг нөхцөл байдал. Сая Баясгалан байцаагч ярилаа. Бид бүхэн хамтраад тэр ковидын дараах нөхцөл байдал 2021 он, 2022 онд яг манай Ус сувгийн удирдах газраас миний гаргасан шийдвэрийн дагуу тухайн үед мэргэжлийн хяналт гэж байсан. Тэр мэргэжлийн хяналтынхантай хамтарч бид бүхэн энэ судалгаа шинжилгээ нянгийн юунуудыг гаргасан. Бүгдийг нь. Буцаагаад энэ бүгдийг гаргаад бид бүхэн яаж энийг нянгүйжүүлээд, яаж байгальд нийлүүлэх вэ гэдэг дээр хөрөнгө мөнгөний асуудал тулгамдаж ирсэн. Яг л нөхцөл байдал, байгаа нөхцөл байдал яг ийм байгаад байгаа юм. Тэгээд би бол зүгээр яах вэ. Эсрэгээрээ Байгаль орчны яамных нь 73 дугаар тогтоол дээр бид бүхэнтэй бол нэг их сайн хамтарч ажиллахгүй байгаа. Аж ахуйн нэгж байгууллагууд нийтдээ 400 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг дөнгөж сая тэр аж ахуйн нэгж байгууллагуудын бохирдлыг яаж бууруулах вэ гэж Энх-Амгалан дарга та асууж байна. Бид бүхэн чадлынхаа хэрээр тэр аж ахуйн нэгж байгууллагууд, манай байгууллагынхан бол хяналт тавьж байгаа юм. Гарч байгаа усан дээр нь дээжсийг нь авч байна. Орж ирж байгаа усных нь дээжсийг нь авч байна.

Манай байгууллага өөрөө цаашилаад шалгадаг, хянадаг, торгодог тийм субъект нь байдаггүй. Яг л ийм юмаа хийж чаддаг. Тэгээд улсын байцаагчийн нөгөө үнэмлэх янз бүрийн юм байдаггүй болохоор бид бүхэн цаашилаад юм нь явж болдоггүй. Тэгээд дараагийн байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллага руу шилжүүлдэг. Хүнс, хөдөө аж ахуйн яамтай бас энэ дээр хамтарч ажилладаг. Энэ 400 хэдэн аж ахуйн нэгж байгууллагуудын бохирдлын хэмжээг бид бүхэн бууруулахгүйгээр дараагийн 25 онд орох 250 мянган метр кубийн багтаамжтай цэвэрлэх байгууламжийг авах юм бол мөн адил л ийм байдал үүснэ. Тэгэхээр бид бүхэн өнөөдөр хамтарч ажиллаж байж л энэ бүгдийн ард гарна гэж би бодож байна. Хамтарч ажиллаж байж. Хамтарч ажиллаж байж энэ бүгдийн ард гарахгүй л бол тухайн нэг байгууллагууд тухайн одоо юу ингээд л яваад л байдаг, яваад л байдаг эцсийн бүлэгт тэгээд л бүх юмыг очиж мөргөөд байдаг.

Тэгээд л ингээд эсрэгээрээ нөгөө явсан байгууллага нь ч юм уу, яасан ч байгууллага нь сүүлдээ нөгөө байгальд стандартад нийцсэн ус нийлүүлээгүй гэдэг үр дүнд хүрч байдаг. Анх эхлээд тэр аж ахуйн нэгж байгууллагаас гарч байгаа бохирдлын хэмжээг бид бүхэн бууруулахгүй бол 3-5 дахин илүү бууруулахгүй байх юм бол бид бүхэн яаж тэрийг стандартад нийцүүлж өгөх юм бэ. Би ажилчдыгаа яаж тэрүүнд хэлэх юм бэ. Тэд нар руу стандартад нийцээгүй ус ирж байгаа нь үнэн. Яг ирж байгаа нь үнэн юм чинь. Тэгээд буцаагаад тэрийг стандартад нийцүүлж гарга гэдэг чинь бас утгагүй асуудал болж гарч ирчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид бүхэн тэр аж ахуйн нэгж байгууллагуудтайгаа хамтарч л асуудлуудаа шийдмээр байгаад байгаа юм. Тэгээд нөгөө Төв цэвэрлэх байгууламж нь зөвхөн цэвэрлээд гаргадаг байгууламж байхгүй юу. Тэрнээс биш хэрвээ стандартын дагуу ус нь хүрээд ирэх юм бол бид бүхэн стандартын дагуу

яг цэвэрлээд л ямарваа нэгэн горим тооцоо ямар нэгэн юм алдагдсан юм бол байхгүй байгаад байгаа. Тэрийг байгальд нийлүүлэхэд 100 хувь нийлүүлж болж байгаа. Стандартад нийцээгүй ус ирснээс болж л энэ асуудлууд ингээж үүсэж байгальд нийлүүлээд байгаад байгаа. Тэгээд энэ бүгд дээр бол одоо Золбоо сайдаар ахлуулсан ажлын хэсэг гарчихсан явж байгаа. Бид бүхэн Барилга, хот байгуулалтын яам дээр. Сая мэргэжлийн хяналт тараад ийш тийшээ шилжээд энэ дээр завсардал гарсан. Тэгэхдээ яах вэ энийг түрүүчийн 7 хоноогоос сэргээж Золбоо сайд дээр бид бүхэн ажлын хэсэг байгуулаад, бөөндөө явж байгаа. Нөгөө аж ахуйн нэгж байгууллагууд дээр яг л адилхан нөгөө тавьдаг шаардлагуудаа бүгдийг нь тавиад л аж ахуйн нэгж байгууллагуудаа хувааж аваад л тэр бохирдлын хэмжээг бууруулах талаас нь ажиллаад явж байгаа. Мөн зөврөөр бохирдол.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: 1 минут нэмээд өгчихье. 2 номерын микрофон. 2 номерын микрофон нэмж хариулаад дуусгая. 1 минут нэмж өгье.

Ц.Төрхүү: Мөн энэ зөврөөр бохир ус нийлүүлэгчийг бас ярьж байх ишг байна. Энэ жишээлбэл хойшоо энэ зуслангийн бүсэд байж байгаа айлууд, гэр хорооллын айлууд маань зөврөөр усаа бас нийлүүлдэг болсон. Аж ахуйн нэгж байгууллагууд бас зөврөөр. Төвлөрсөн шугамд холбогдохгүй аж ахуйн нэгж байгууллагууд бүгдээрээ зөврөөр усаа нийлүүлдэг болсон. Манай байгууллагаас бас цооногийг нь гаргаж өгдөг. Энэ Улаанбаатар хотод нийтдээ 6 цооног байсны 2-ыг нь хаачихсан байж байгаа. 4 цооног ажиллаж байгаа.

Тэгээд энэ зөврөөр ирж байгаа бохирдлын хэмжээ яагаад ийм их байна вэ гэхээр энэ айлууд маань намар 1 соруулдаг, хавар 1 соруулдаг. Тэгээд тэр дунд нөгөө лаг болон ямарваа нэгэн бохирдол нь өвөлжингөө байж байгаад

исчихсэн байж байна. Тэгээд тэрийг соруулж авчраад буцаагаад манай төвлөрсөн шугамд хийхээр төв цэвэрлэх байгууламж дээр ирж байгаа нөгөө бохирдлын хэмжээ өндөр гарч ирж байна. Энэ аж ахуйн нэгж байгууллагуудтай бас өчигдөрхөн бид бүхэн тэр зөвөөрлөж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудтай уулзаж.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Төрхүү даргад баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Мэдээлэлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу. Бат-Амгалан гишүүнээр тасаллаа. Бат-Амгалан гишүүн саналаа хэлье.

Э.Бат-Амгалан: Би энэ нийслэл Улаанбаатарчуудад хэрэгтэй 1 санал хэлье гэж бодоод байна. Энэ түрүүн асуултдаа ч ярьж байсан. Баянзүрх дүүргийн 23, 28 дугаар хороонд байрлах ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс гээд 240 га орчим газрыг Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулийн дагуу өөрийнхөө бүрэн эрхийн дагуу олон улсын цэцэрлэгт хүрээлэн хийхээр ингээд шийдвэр гаргаад яваад байгаа юм байна лээ. Энэ нь тэгээд одоо ажил хэрэг болохгүй, бүх шатад гацаад, яг ний нуугүй хэлэхэд манай энэ төрийн байгууллагуудын дунд шатын дарга нарын хоорондын үл ойлголцол, уялдаа холбоо байхгүй. Энэ байдлаас болоод гацаад байна л гэж би бол Баянзүрх дүүргээс сонгогдсон гишүүний хувьд харж байгаа. Энэ бол зөвхөн Баянзүрх дүүргийн иргэдтэй хамаатай асуудал биш. Эсвэл тэндээс сонгогдсон Улсын Их Хурлын хэсэг бүлэг гишүүдийн асуудал биш. Энэ ерөөсөө нийслэл Улаанбаатар хотын нийт иргэдийн, Монгол Улсын тал хувь нь амьдарч байгаа 1 сая 600 мянган иргэдийн асуудал.

Хамгийн нэгдүгээрт энд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй адилхан төстэй тийм хэмжээний олон улсын цэцэрлэгт хүрээлэн хийчих ийм боломж бололцоотой газар. Үүнээс цааш дахиж

ийм газар нэгдүгээрт Улаанбаатарт бол байх ч үгүй, олдох ч үгүй.

Хоёрдугаарт иргэд чөлөөт цаг заваа зөв боловсон өнгөрүүлэх гол ач холбогдолтой. Дараагийн хамгийн гол асуудал энэ агаар орчны бохирдлыг бас багасгах. Тэнд мэдээж ногоон байгууламж, Ерөнхийлөгчийн гаргасан 1 тэрбум модны хөдөлгөөн тэнд таригдах ийм боломжууд, дээрээс нь энэ ундны усны эх үүсвэрийнхээ хамгаалалтын бүсийг бүр албан ёсоор сайхан хамгаалж авч цэцэрлэгт хүрээлэн хийх ийм боломжтой. Мөн дээрээс нь бид нарын ярьж байгаа төвлөрлийг сааруулах, түгжрэлийг багасгах маш олон төрлийн ач холбогдолтой ийм шийдвэр Баянзүрх дүүрэг дээр гарчхаад байгаа юм. Тийм учраас би яг юу гэх гээд байна гэвэл Баянзүрх дүүргээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд энэ дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гаргасан шийдвэрийг та бүхэн минь яг газар дээр нь очиж нэг үзээч ээ. Би энд бүр сайхан бичээд гаргаад ирлээ. 7 байгууллагын яг шийдвэр гаргах түвшиний удирдлагууд, сайд нар, дэд сайд нарын хэмжээнд Баянзүрх дүүрэг дээр ажиллаж та бүхэн минь өгөөч гэж. Байгаль орчны яам, Барилгын яам, Нийслэлийн газрын алба, Ус сувгийн удирдах газар, Нийслэлийн байгаль хамгаалах газар, Ерөнхий төлөвлөгөөний газар, Усны газар гэсэн энэ 7 газар, өөр дээр нь ямар газрууд нэмэгдэх юм. Эрх бүхий тэнд энэ яг цэцэрлэгт хүрээлэнтэй холбоотой, ундны усны эх үүсвэрийг хамгаалахтай холбоотой, агаар орчны бохирдлыг багасгахтай холбоотой. Тэгээд цаашидаа энэ төвлөрлийг сааруулах энэ томоохон энэ ажлыг дэмжиж өгөөч. Би түрүүн бас хэлсэн 2008 онд анх Үндэсний цэцэрлэгт хүрээлэн байгуулагдаж байхад маш олон асуудлуудтай бол тулгарч байсан. Би анхных нь орлогч даргаар ажиллаж байсан. Тэгээд өнөөдөр бол энэ үндэсний цэцэрлэгт хүрээлэн нийслэлчүүдийн тодорхой хэмжээнд тэнд очдог, амралт чөлөөт цагаа өнгөрөөдөг ийм цэцэрлэгт хүрээлэн

болчихсон. Үүний 2 дахь нь Баянзүрх дүүрэг дээр хийгдэхээр ийм боломж, бололцоо гарчихсан байгаа юм. Тэгээд саяын миний хэлсэн энэ 7, 8 газрын удирдлагууд ажлын хэсэг гэдэг юм уу, ямар нэгэн байдлаар Баянзүрх дүүрэг дээр очиж ирэх 7 хоногт, 4 сардаа багтааж ажиллаж өгч, энд тодорхой шийдвэр гаргаж өгөөч гэсэн ийм санал байна.

Б.Энх-Амгалан: Бат-Амгалан гишүүнд баярлалаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.1-д заасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал хамаардаг. Үүнтэй холбоотойгоор үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, ундны усны хангамж, нөөц аюулгүй байдлын талаар өнөөдөр экологийн аюулгүй байдлын талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонслоо.

Мэдээлэлд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Хот байгуулалт, хөгжлийн газар, Усны газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Ус сувгийн удирдах газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Стандарт хэмжил зүйн төвийн холбогдох мэргэжлийн хүмүүс оролцлоо. Оролцсон нийт гишүүд, нийт ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Өнөөдөр тулгамдсан нэлээн олон асуудлуудыг бид сонсож, протоколд тэмдэглэж, хөтөлж авсан. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороотой хамтраад цаашид энэ асуудлаар ер нь бол нээлттэй хэлэлцүүлэг хийх ийм саналыг бас гишүүд гаргаж байна. Энэ асуудлуудыг уламжилна. Тэгээд энүүгээр дахин нээлттэй хэлэлцүүлэг хийж, энэ асуудлуудыг төрийн бодлогын хэмжээнд

аваачиж, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх болоод бусад холбогдох арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.

Мөн энд оролцсон мэргэжлийн хүмүүсийн хэлж, ярьж байгаагаар бол ажлаа уялдуулж бүгдээрээ хамтарч энэ асуудлаас гарахгүй бол 1 байгууллага, 1 газар, 1 яам бол энийг дангаараа шийдэх бололцоо боломж байхгүй гэдэг нь бол харагдлаа.

Сонсголд оролцсон нийт ажлын хэсгийн гишүүд, гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Баярлалаа.

15.50 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
Э.СУВД-ЭРДЭНЭ